# СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 01 Улаанбаатар хот

| № | Зорилт /бодлогын үндэслэл/ | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Үр дүнгийн | | 2023 онд шаардлагатай хөрөнгө | | Хэрэгжүү-лэх байгууллага | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин /2022 он/ | Зорилтот түвшин /2023 он/ | Санхүүжил-тийн хэмжээ /сая төгрөг/ | Санхүү жил-тийн эх үүсвэр | | | |
| | | | | | | 78,431.9 | Нийт | | | |
| Нэг.Хүний хөгжлийн бодлого/ Боловсролоор тэргүүлэх Сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | |
| 1 (2.1.) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, "ИРГЭН ТӨВТ" үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | | | |
| 1 | ДЗДҮАХ-1.1.1 | Гэр хорооллын, айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. | Ариутгал хийх нүхэн жорлонгийн тоо, Нийтийн эзэмшлийн зам талбайн хэмжээ | Ариутгалын ажлаар 14007 өрхийн бохирын цоог, нийтийн эзэмшлийн 357139.3 м2 талбайг 2 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэсэн байна. | 9,11-20 дугаар хорооны 14007 өрхийн бохирын цооног, нийтийн эзэмшлийн 357139.3 м2 талбайд 2 удаагийн давтамжтай ариутгалын ажлыг зохион байгуулана. | 700.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууцны хороолол дундах хүүхдийн тоглоомын талбай, хогын сав, гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, бохирдсон хөрстэй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ариутгал халдваргүйтгэл хийх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 оны 04-р сарын 17-ны өдрөөс 2023 оны 04-р сарын 26-ны өдрүүдэд, 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрийн хооронд 2023 онд нийт 2 удаа хийгдэж гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. Ариутгалыг гүйцэтгэхэд ариутгалын 12 баг томилон, Зориулалтын мананцар үүсгэгч 5 тонн хэмжээтэй цистерн автомашин, 2 портер, 9 суудлын жижиг тэрэг, 41 хүний бүрэлдэхүүнтэйгээр гэр хорооллын 12988 айл өрхийн бохирын жорлон, цооног, 187,990м2 хүүхдийн тоглоомын талбай, 106,399м2 үерийн гуу жалга, 79441м2 шар усны үерийн холбоотойгоор айл өрхийн бохирын жорлон хальж урссан талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хавар намрын улиралд 2 удаа хийж гүйцэтгэсэн.<br><br>2023.07.04-10 ны өдрүүдэд үерийн улмаас нийтийн эзэмшлийн гудамж талбай, айл өрхийн лаг шавар үүссэн байршилуудад Нийтийн эзэмшлийн 122,548м2 талбайд, гэр хорооллын айл өрхийн 13854 айл өрхийн жорлон бохирын цооногт ариутгал халдваргүйтгэл, 8 сарын 07-12 ны өдрүүдэд үерийн усанд өртсөн 15, 16, 18-р хорооны айл өрхийн жорлон бохирын цооног нийтийн эзэмшлийн 198,313м2 талбайд ариутгал халдваргүйтгэл, 9 сарын 04-07 ны өдрүүдэд сэлбэ голын далан болон орон сууцны хороолол дундах 30650м2 талбайд 6 удаагийн давтамжтайгаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэсэн байна. | |
| 2 | ДЗДҮАХ-2.1.1 | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн эмнэлгийн барилгын ажлын явц 70%-тай байна. | Дүүргийн эмнэлгийн барилгын ажлыг 90%-д хүргэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэнэ. | 15,059.8 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих ажлын нэмэлт ажлыг 15.5 тэрбум төгрөгийн барилга угсралтын төсөл, арга хэмжээг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.01.30-ны өдрийн 6/193 дугаартай албан бичгээр хүргүүлсэн ба худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж 2023.04.11-ний өдөр гэрээ байгуулсан, гэрээний шатанд хэрэгжиж байна. | 80% |
| 3 | | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж барих газар чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт хувиар | Шинээр | Шаардлагатай хэмжээнд газар чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ. | 3,450.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Нийслэлийн Засаг даргын 01119-А/919/2021 захирамжаар Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр 1461704648 нэгж талбарын дугаартай 11096 м2 газрыг чөлөөлж газар эзэмших гэрчилгээ авсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Нэгдсэн эмнэлгийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | Хэрэгжилт хувиар | Шинэээр | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 5,000.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн төсвийн хөрөнгөөр эмнэлгийн төвлөрсөн ариутгал, амбултори, лаборатори, дуран, дүрс оношлогооны тоног төхөөрөмж, компьютер тоног төхөөрөмж тавилга худалдан авах нийт 5 тэрбум төгрөгийн төсөвтэй 95 нэр төрлийн 620 ширхэг бараа худалдан авах худалдан авалтын захиалгыг боловсруулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.01.30-ны өдрийн 6/192 дугаартай албан бичгээр дүүргийн худалдан авах ажиллагааны албанд шилжүүлсэн. Худалдан авалтын захиалгын гүйцэтгэл 100%. Үүнээс ХААА-нд 8 багц тендер зарлагдсан бөгөөд 4.2 тэрбум төгрөгийн 7 багцад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, үүнээс 3.5 тэрбум төгрөгийн нэгдсэн дүрс оношилгоо, лаборатори, PCR, амбултори, тоног төхөөрөмж, тавилга гэсэн 6 багцад гэрээ байгуулан, бүрэн хээргжүүлсэн. Төвлөрсөн ариутгалын тоног төхөөрөмж авах 1 төсөл гэрээ байгуулагдахаар хуулийн хугацаанд хүлээгдэж байна. Дуран оношлогоо худалдан авах 1 төсөл худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. | 87.5 % |
| 5 | МУХТ 2.1.6, НХТЖҮЧ 2.11.1, НЗДҮАХ 2.1.8, ДЗДҮАХ-2.1.2 | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Тоног төхөөрөмжийн тоо | Шинээр | Шаардлагатай тоног төхөөрөмжүүд авч, ашиглана. | 385.9 | Улсын төсөв | ЭМТ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэн, эрүүл мэндийн боловсрол олгох, нийгэм, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс дүүргийн Засаг даргын 2023 оны "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэн ажиллах тухай" А/517 дугаар захирамжийн дагуу 26,033,000 төгрөгийн санхүүжилтээр дүүргийн Эрүүл мэндийн төвийн нэг давхрын өрөөг Хөгжлийн бэрхшээлтэй онцлог, хэрэгцээ, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шаардлага, чадамжид тулгуурлан үзлэг оношилгоо хийх зориулалтаар тохижуулав.. | |
| 6 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1, НЗДҮАХ-2.1.5, НХТ-1.1.15, 1.1.15, ДЗДҮАХ-2.1.3 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг тооцож ажиллана. | Гэрээний гүйцэтгэлээр | Гэрээний гүйцэтгэлээр 2022 оны эхний хагас жилд А-6, В-7, С-3 үнэлгээтэй байна. | Гэрээний гүйцэтгэлийн дүнгээр С буюу Ажил сайжруулах үнэлгээтэй 3 ӨЭМТ-ийн үнэлгээний түвшинг ахиулна. | | Дүүргийн төсөв | НХХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны А/265 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандартын хэрэгжилт болон удирдлага, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд ажлын байранд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний 2023 оны эхний хагас жилийн биелэлтээр Бүрэн хангалттай үнэлгээтэй 1,2,7,10,11,13,14,17 дугаар хорооны ӨЭМТ, Хангалттай үнэлгээтэй 3,4,5 6,9,12,15,16,18,19,20 дугаар хорооны ӨЭМТ, Ажил сайжруулах үнэлгээтэй 8 дугаар хорооны ӨЭМТ дүгнэгдэж, гэрээний дундаж биелэлт 89% буюу өмнөх оны мөн үеэс 3,7%-иар өссөн. | 100% |
| 7 | МУХТ-2.1.26, НЗДҮАХ-2.1.5, НХТ-1.1.14, ДЗДҮАХ-2.1.4 | Төрөлжсөн нарийн мэргэшлийн эмч нарыг дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | Шинээр | 15 эмч, эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлнэ. | 50.0 | Дүүргийн төсөв | НХХ | Сүхбаатар Эрүүл мэндийн төвийн статистикч дүн бүртгэгч 1 сувилагч, дотрын 1 эмч төрийн сангийн зардлаар суралцсанаар мэргэшсэн хүний нөөцийн тоог нэмэгдүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны А/478 дугаар захирамжаар 3,825,000 төгрөг шийдвэрлэн, томуу, томуу тест өвчний идэвхжил, дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах, амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх, яаралтай арга хэмжээ авах чадавхжуулах сургалтад Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн 85 эмч, мэргэжилтэн хамрагдсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.8.1, НЗДҮАХ-2.1.4, НХТ-1.1.13, ДЗДАХ-2.1.5 | Сүхбаатар ЭМТ-ийн харъяа Салбар амбулатори 1-ийг түшиглэн Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | Барилгын ажлын гүйцэтгэлээр | Барилгын карказ угсралт, шавар, өрлөгийн ажил дууссан. Барилгын ажлын явц 80%-тай байна. | Барилгын ажлыг 100% гүйцэтгүүлнэ. | 942.60 | Улсын төсөв | ЭМТ | Шинээр баригдаж буй Салбар амбулатори 1-ийн барилгыг түшиглэн Эрүүл мэндийг дэмжих төв байгуулахаар төлөвлөсөн. Уг барилга 2,6 тэрбум төгрөгийн өртөгтэй, 25мх15м хэмжээтэй 5 давхар, барилгын ажлыг 2020 оны 6 дугаар сараас эхлэн Кенжуки ХХК гүйцэтгэж байна. Барилгын карказ угсралт, шавар, өрлөгийн ажил дууссан, гадна тохижилт, дотор засал, цахилгаан, сантехникийн ажил хийгдэж байна. Барилгын ажлын явц 80%-тай байна.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Салбар амбулатори 1 болон Эрүүл мэндийн төвд 1,970 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдэхээр гэрээ байгуулсан. | 80% |
| 9 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.6.1, 2.8.1, НЗДҮАХ-2.1.1, НХТ-1.1.1, 1.1.2, ДЗДҮАХ-2.1.6 | "Иргэн төвт" эрүүл мэндийн явуулын үйлчилгээг өргөжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны 171 дүгээр захирамжаар 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт зориулж ӨЭМТ-дэд 7,400,000 төгрөгийн 3 төрлийн эмнэлгийн багаж, хэрэгсэл олгосон. | 18-аас дээш насны зорилтот бүлгийн иргэдийг явуулын үйлчилгээгээр эрт илрүүлэг үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулна. | 10.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, шинжилгээ, оношилгоонд хамруулах, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хэрэгжүүлэн "Иргэн төвт" явуулын үйлчилгээг хуваарийн дагуу 1-20 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Дүүргийн нийт 20 хорооны 1264 иргэнийг үзлэгт хамруулж, илэрсэн өвчлөлийн 206 тохиолдлыг хяналтад авч, эмчилгээнд хамруулсан. | 100% |
| 1.2 (2.2) Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | | | |
| 10 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1, НЗДҮАХ-2.1.7, НХТ-1.1.1, 1,1.2, ДЗДҮАХ-2.2.1 | Эрт илрүүлгийн багцын үзлэгт иргэдийн идэвхи, санаачлага оролцоог чиглүүлж, төр, хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллана. | Хамрагдалтын хувиар | Үзлэгт 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 144542 иргэнээс 25089 буюу 18%-ийг хамруулж, хавдрын 57 сэжигтэй тохиолдол илрүүлсэн. | Эрт илрүүлгийн багцын үзлэгийн хамрагдалтыг 30-40%-д хүргэнэ. | | Сүхбаатар Эрүүл мэндийн төвийн бүрдүүлсэн төсөв | ЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сөүл эмнэлэг, Рехамид, Клинико, Мон-медикал эмнэлэгтэй хамтран иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцийн үзлэг, шинжилгээнд хамруулж байна. Үзлэгт хамрагдвал зохих 142444 иргэнээс 2023.11.01-ний | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байдлаар 57380 буюу 41%-ийг хамруулж, хавдрын сэжигтэй 97 тохиолдлыг илрүүлэн дараагийн шатлалын эмнэлэгт илгээсэн. Хавдрын сэжигтэй тохиолдлын 19%-ийг 31-45 насны иргэд, 42%-ийг 46-60 насны иргэд, 41%-ийг 61-ээс дээш насны иргэд тус тус эзэлж байна.<br>Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд 74 хүн хамруулж, өндөр эрсдэлтэй 4 иргэнийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, биохимийн шинжилгээ өгөхийг зөвлөсөн.<br>"БЗДХ-аас сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулж, их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нар, зочид буудлын эзэд, үүд баригч нийт 162 хүнийг хамруулсан. | |
| 11 | НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2, НХТ-1.1.2, ДЗДҮАХ-2.2.3 | Амьсгалын замын өвчлөлийг бууруулж, сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амыг эрт илрүүлэг үзлэгт хамруулж, оношлогдсон тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулна. | Хамрагдсан хүний тоо | Зорилтот бүлгийн 3068 иргэдийн дунд сүрьеэ өвчний эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж, сүрьеэгийн 6 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан. | Сүрьеэгийн эрт илрүүлэгт хамрагдах иргэдийн тоог өмнөх оноос 200-300 иргэнээр нэмэгдүүлнэ. | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | ЭМС-ын 2017 оны Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах А/145, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын А/65 дугаар тушаалаар төрийн болон төрийн бус боловсролын 109 байгууллагын 3144 багш, албан хаагчдыг үзлэгт хамруулж, урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл өглөө. Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт 1 сэжигтэй тохиолдол илэрч, онош тодотгох шинжилгээнд илгээсэн.<br>2023 оны 9 дүгээр сарын 5-нд Өрхийн Эрүүл мэндийн төвийн 16 вакцинатор сувилагч, 14 Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудад улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангасан.<br>Эрсдэлт бүлгийн хүн ам болон амьжиргааны I, III бүлгийн иргэдийн судалгааг үндэслэн МӨАУМХ-той хамтран | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт 1993 иргэн хамруулж, хэвийн бус буюу сэжигтэй 30 тохиолдол илрүүлэн, 28 тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулж, нян судлалаар 4 тохиолдол батлагдсанаас мэдрэг сүрьез 2, эмд тэсвэртэй сүрьеэ 1 тохиолдол илэрч, эмчилгээнд хамруулсан. Дүүргийн Цагдаагийн 1,2-р хэлтэстэй хамтран архины хамааралтай 103 иргэнийг сүрьеэгийн илрүүлэгт хамруулж, рентген шинжилгээнд өөрчлөлтэй 5 тохиолдол илрүүлж, 3 тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулахад халдвартай тохиолдол бүртгэгдээгүй. Дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран Глобаль сангийн дэмжлэгтэйгээр сүрьеэгийн төслийн хүрээнд орон гэргүй 73 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сэжигтэй 1 тохиолдлоос цэрний шинжилгээ авахад халдвар илрээгүй. ҮУПК, Монгол Улсын Консерватор ХБК, Нэкст эдукейшн сургуулийн 1616 оюутан, сурагчдад БЗДХ, ДОХ, сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, цэрний шинжилгээнд 5 тохиолдол хамруулж, халдвар илрээгүй. | |
| 12 | | Эмч эмнэлгийн ажилтнуудыг хөдөлмөрийн эрүүл аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, Сүрьеэгийн диспансерийн агааржуулалтын системийн агаар шүүгчийг шинэчилнэ. | Филтерийн тоо | Дүүргийн Засаг даргын 2020 оны А/340 дүгээр захирамжаар "Сүрьеэгүй дүүрэг" аяны хүрээнд агаар шүүгчийн 2 филтер шинэчилсэн. | Агаар шүүгчийн 2 ширхэг филтер солино. | 2.0 | Дүүргийн төсөв | НХХ | Эмч, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан ажиллах нөхцөлөөр хангаж, иргэдийг сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох үүднээс дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/63 дугаар захирамжаар Сүхбаатар Эрүүл мэндийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төвийн Сүрьеэгийн диспансерт агаар сэлгэх төхөөрөмжийн 2 ширхэг агаар шүүгч шинээр авахад 1,720,000 төгрөг шийдвэрлэсэн. | |
| 13 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.6.1 НЗДҮАХ-2.1.2, НХТ-1.1.3, ДЗДҮАХ-2.2.5 | Товлолт болон товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тандалтыг бэхжүүлнэ. | Хамрагдалтын хувиар | Товлолт дархлаажуулалтад 10794 хүүхэд хамруулахаас 9972 хүүхэд буюу 92% хамруулсан нь өмнө оны мөн үеэс 4%-иар буурсан. | Хамрагдалтыг өмнөх оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ. | 3.0 | Дүүргийн төсөв | НХХ | Заавал хийх үндэсний товлолын дархлаажуулалтад 2023 оны эхний 8 сарын байдлаар 20645 хүүхэд хамруулахаас 20038 хүүхэд буюу 97%-тай өмнөх оны мөн үеэс 2%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>Нөхөн дархлаажуулалтаар тавтын вакцинд 423 халдварт саагийн вакцинд 443, УГУ вакцинд 347 , ВГА вакцинд 256, ПЭВ-д 425 , В гепатитийн вакцинд 1, БЦЖ вакцинд 1, сахуу, татрангийн эсрэг вакцинд 13, тарьдаг саагийн вакцинд 149 хүүхэд буюу 2058 нийт хүүхэд хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 85 хүүхдээр нэмэгдсэн байна. | 100% |
| 14 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1, НЗДҮАХ-2.1.13, ДЗДҮАХ-2.2.7 | Сүхбаатар Сувиллын газрыг уламжлалт эмчилгээ, өдрийн эмчилгээний чиглэлээр өргөжүүлж, эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Сувиллын уламжлалт эмчилгээний 10, сэргээн засах 8 төрлийн эмчилгээ үзүүлж байна. | Уламжлалт 14 төрлийн 21 эмчилгээ болгон, өдрийн эмчилгээ эхлүүлнэ. | 20.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Сувиллын тусламж үйлчилгээг уламжлалт эмчилгээний 10, сэргээн засах эмчилгээний 8 төрлөөр үзүүлж байна. Цаашид уламжлалт эмчилгээ, өдрийн эмчилгээний чиглэлээр хөгжүүлэн, уламжлалт 14 төрлийн 21 эмчилгээ болгон өргөжүүлэхэд шаардлагатай 17 төрлийн багаж, хэрэгслийн төсвийн саналаа 2024 оны төсөвт тусгасан. | 90% |
| 15 | НХТЖҮЧ 2.4 НЗДҮАХ-2.3.4 ХАХТ-2.3.4.1 ДЗДҮАХ-2.2.8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин, боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Боловсролд хамрагдсан хүүхдийн тоо | 18 удаагийн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй 300 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй 292 хүүхэд цэцэрлэг, сургуульд хамрагдаж байна. | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоог 50-иар нэмэгдүүлнэ. | 3.0 | Дүүргийн төсөв | НХХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар байгуулагдсан Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар байнгын асаргаа шаардлагатай 1 дүгээр ангид элсэх 49 хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийн хамт оролцуулан, хамран сургах тойрог болон суралцагчийн хүсэлтийн дагуу холбогдох ерөнхий боловсролын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургуулиудад илгээх бичгээр боловсролд хамруулах шийдвэр гаргаж, боловсролд хамрагдалтыг 49 хүүхдээр нэмэгдүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/229 дүгээр захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд 5.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 16 | | Хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд тохирох сургалтын хэрэглэгдэхүүн туслах хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцлийг сайжруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Шинээр | 25 дугаар сургууль, 186 дугаар цэцэрлэгийн танхимыг тохижуулна. | 60.0 | Дүүргийн төсөв | НХХ | -Хүүхдийн сурах, хөгжих ээлтэй орчныг бүрдүүлэн, дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу 60,0 сая төгрөгийн санхүүжилтээр 186-р цэцэрлэгт Хүүхэд хөгжлийн танхим, 25-р сургуульд хэл засал, хөдөлмөрт бэлтгэх танхимуудыг тохижуулав. | 100% |
| 1.3 (2.3) Иргэдийг нийтийн бие тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | | |
| 17 | НЗДҮАХ-2.2.1.. ДЗДҮАХ-2.3.1 | Дүүргийн хэлтэс, албад, хороодын албан хаагчдын дунд спорт наадам, өдөрлөгүүд зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Спорт наадам 2022" тэмцээнийг спортын 4 төрлөөр зохион байгуулж, 16 хэлтэс, албадын 650 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. | Спорт наадам-2023 тэмцээнийг спортын 3 төрлөөр өргөжүүлж, оролцогчдын тоо, амжилтыг ахиулна. | 35.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/26 дугаар тушаалын дагуу 2023 оны 03 дугаар сарын 31, 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд спортын 5 төрөлт /дартс, волейбол, ажлын байрны дасгал, буухиа, сагсан бөмбөг/ тэмцээнийг зохион байгуулж, 6 багийн 148 тамирчид өрсөлдөж, эхний 4 байрыг шалгаруулж, 8,868,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. 2023 оны 09 дүгээр сарын 29, 30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан нийслэл, дүүргийн ажилтан, албан хаагчдын спортын 5 төрөлт тэмцээнд Засаг даргын Тамгын газраас давхардсан тоогоор 48 албан хаагч оролцож, ширээний теннисний хосын төрөлд Б.Жаргал, Б.Энхбаатар | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нар шалгарч алтан медаль хүртлээ.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/476 дугаар захирамжаар дэргэдэх хэлтэс, албадын ажилтан албан хаагчдын дунд Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг 2023 оны 12 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулж, давхардсан тоогоор 848 тамирчин оролцлоо. Тус тэмцээнд 38,603,000 төгрөг зарцуулсан. | |
| 18 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спорт өдөрлөг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, оролцогчдын тоо | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хонхот бөмбөг, суугаа волейболын тэмцээн зохион байгуулж, 168 иргэн хамруулсан. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд спортын тэмцээн зохион байгуулж, 90 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч оролцуулна. | 3.0 | Дүүргийн төсөв | НХХ | ЕБ-ын 29-р сургуулийн 60 жилийн ойг тохиолдуулан ахмад багш Дашдэндэвийн нэрэмжит гар зургийн уралдаанд бага 1-5 анги, дунд 6-9 анги, ахлах 10-12 ангийн 30 сургуулийн 334 сурагч хамрагдсанаас 60 сурагч шагналт байрыг эзэлсэн.<br><br>- Монголын Хонхтой бөмбөгийн холбоотой хамтран дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хонхтой бөмбөг" аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг зохион байгууллаа. Уг тэмцээнд 4 дүүргийн эрэгтэй 4, эмэгтэй 3, нийт 7 багийн 35 тамирчид оролцсон. Эрэгтэй төрөлд: I байрт Сүхбаатар дүүргийн баг, II байрт Хан-Уул дүүргийн баг, III байрт Сүхбаатар дүүргийн баг, Эмэгтэй төрөлд: I байрт Сүхбаатар дүүргийн баг, II байрт Сонгинохайрхан дүүргийн баг, III байрт Хан-Уул дүүргийн баг тус тус шалгарлаа. Хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд тохирох сургалтын хэрэглэгдэхүүн туслах хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцлийг сайжруулна.Дүүргийн биеийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тамир, спортын хороотой хамтран "Суугаа волейбол"-ын нээлттэй тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 29 дүгээр сургууль дээр зохион байгуулж, 9 багийн 54 тамирчин оролцлоо.<br><br>2023 оны 09 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадамд 146 тамирчин спортын 5 төрлөөр /пара волейбол, дифлимп волейбол, дифлимп ширээний теннис, тусгай волейбол, бочи/ оролцож, 4 алт, 4 мөнгө, 6 хүрэл медалиар шагнагдаж, улсын хэмжээнд Тэргүүн байрт шалгарсан.<br><br>- Герман Улсын Берлин хотод зохиогдсон Тусгай Олимпийн зуны 16 дахь наадамд Бадминтоны төрлөөр 25 дугаар сургуулийн 4 тамирчин оролцож, 3 алт, 1 хүрэл медаль авчирсан.<br><br>- Монголын Тусгай олимпийн 10 жилийн ойд зориулагдсан үндэсний спортын наадамд Бадминтоны төрлөөр Сүхбаатар дүүргийн баг тамирчид оролцож, багийн дүнгээр 2-р байр эзэлж, мөнгөн медалийн эзэд боллоо. | |
| 19 | НХТЖҮЧ - 3.5.4<br>НЗДҮАХ-2.2.2<br>ХАХТ-2.2.2.5<br>ДЗДҮАХ-2.3.2 | Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг улс, нийслэлийн тэмцээнүүдэд бэлтгэн оролцуулна. | Өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тоо | Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг ширээний теннис, 100 буудалт даам, сагс, 3х3, волейбол, хөл бөмбөг, үндэсний бөх, шатрын төрлөөр зохион байгуулж, 3858 хүүхдийг хамруулсан. Улсын | Нийслэл, улс, олон улсын чанартай тэмцээнд оролцож, медалийн чанарыг ахиулна. | 80.0 | Дүүргийн төсөв | НХХ | Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Улаанбаатар Лиг" сагсан бөмбөг, волейболын төрөлт тэмцээний сагсан бөмбөгийн төрөлд дүүргийн баг тамирчид 3 насны ангиллаар оролцож, шилдэг дасгалжуулагч 1, шилдэг тоглогч 2, алт 2, мөнгө 1, хүрэл 2 медаль хүртсэн амжилт үзүүлсэн.<br>Ерөнхий боловсролын сургуулиудын "Уран хөдөлгөөнт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | аварга шалгаруулах тэмцээнээс алт 2, хүрэл 4, нийслэлийн тэмцээнээс мөнгө 5, хүрэл 1 медаль хүртсэн. Өсвөрийн шигшээ багт 78ш тоглолтын хувцас, хэрэглэл авсан. | | | | | гимнастик"-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд бага насны төрөлд Шинэ зууны удирдагч сургууль, 2 цэцэрлэг оролцож, тусгай байруудад шалгарсан. Дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/76 захирамжаар Хүүхдийн спортын VII наадмын анхан шатны тэмцээнд 84,844,0 төгрөг, 2023 оны 05 дугаар сарын А/258 дугаар захирамжаар Монголын хүүхдийн спортын шигшээ тэмцээнд оролцоход 244,0 сая төгрөгийг зарцуулж,, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 290 тамирчин, 30 багш дасгалжуулагч, нийт 320 хүний бүрэлдэхүүнтэй спортын 21 төрлөөр оролцож, алт-21, мөнгө-19, хүрэл 21 медалийг тус тус хүртэж, улсын хэмжээнд ДЭД байрт шалгарсан. | |
| 20 | | Багш, дасгалжуулагч, баг тамирчдыг хот, улс, олон улсын тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн Багш, дасгалжуулагч, баг, тамирчдын тоо, санхүүжилтийн хэмжээ | АНУ-ын Флорида мужийн Орлонда хотод зохион байгуулагдсан өсвөрийн Дэлхийн аварга шалгаруулах хөгжөөн дэмжигчдийн тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцсон Эрдмийн хөтөч цогцолбор сургуулийн Болор шигтгээ-3 хамтлагийн багш, сурагчдын зардалд 50 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, 6-р байрт шалгарсан. | Хот, улс, олон улсын тэмцээнд оролцсон баг, тамирчдын амжилтыг ахиулсан байна. | 100.0 | Дүүргийн төсөв | НХХ | Монголын хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ 290 тамирчин, 30 багш дасгалжуулагч нийт 320 хүний бүрэлдэхүүнтэй спортын 21 төрлөөр оролцож, алт-21, мөнгө-19, хүрэл 21 медалийг тус тус хүртэж улсын хэмжээнд ДЭД байрт шалгарсан. Дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны А/315, 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/497, А/489, А/494, А/491 захирамжаар нийт 5 иргэнд Азийн болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд дэмжлэг үзүүлж, нийт 22,500,0 төгрөгийн санхүүжилт үзүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | НХТЖҮЧ - 3.5.3 НЗДҮАХ- 2.2.1 ХАХТ - 2.2.1.4 ДЗДҮАХ- 2.3.3 | Иргэдийн спортын XI наадам зохион байгуулна. | Зохион байгуулах арга хэмжээ, оролцогчдын тоо | Иргэдийн спортын X наадмыг 8 төрлөөр зохион байгуулан нийт 2266 иргэд хамруулж, шалгарсан багуудыг нийслэлийн шатанд оролцуулахаар бэлтгэл хангасан. | Иргэдийн спортын XI наадамд 1-20 дугаар хороодын оролцоог идэвхжүүлэн, оролцогчдын тоог 850 аар нэмэгдүүлж, нийслэлийн шигшээ тэмцээнд амжилттай оролцуулсан байна. | 55.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн "Иргэдийн спортын XI наадам" зохион байгуулах тухай А/438 дугаар захирамжийн дагуу 74,020.000 төгрөгийн санхүүжилтээр дүүргийн Иргэдийн спортын наадмыг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд спортын 9 төрлөөр /спорт явган аялал, ширээний шагайн наадгай, дартс, олс таталт, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, сагсан бөмбөг/ зохион байгуулж, нийт 19 хорооны 131 багийн 1806 иргэн оролцож, нэгдсэн дүнгээр тэргүүн байрт Х.Батжаргал Засаг даргатай 11-р хорооны баг тамирчид, дэд байрт Б.Эрдэнэсүх Засаг даргатай 16-р хорооны баг тамирчид, Гутгаар байрт Ш.Батдорж Засаг даргатай 19-р хорооны баг тамирчид тус тус шалгарсан. Шалгарсан баг тамирчдыг нийслэлийн шигшээ тэмцээнд оролцуулахад дүүргийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/509 захирамжаар 19,920,000 төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 22 | | Монголын хүүхдийн спортын VII наадамд өвөл, зуны спортын төрлүүдээр оролцоно. | Зохион байгуулах арга хэмжээ, хувиар | - | Дүүргийн шатны тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан багуудыг нийслэлийн шатны тэмцээнд оролцуулсан байна. | 150.0 | Дүүргийн төсөв | НХХ | Монголын хүүхдийн спортын VII наадмын өвлийн спортын төрөлд Сүхбаатар дүүргийн тамирчид алт 7, мөнгө 3, хүрэл 4 медаль авч, Нийслэлийн хэмжээнд 1-р байрт шалгарсан. Хүүхдийн спортын VII наадмын зуны төрлийн анхан шатны тэмцээн болох Сүхбаатар дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 03 сарын 01-ээс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд спортын 15 төрлөөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн 31 сургуулийн 2700 гаруй | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сурагчид оролцож, шилдгүүдээ тодруулсан. Монголын хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ 290 тамирчин, 30 багш дасгалжуулагч, нийт 320 хүний бүрэлдэхүүнтэй спортын 21 төрлөөр оролцож, дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/76 захирамжаар анхан шатны тэмцээн зохион байгуулахад 84,844,000 төгрөг, 2023 оны А/258 дугаар захирамжаар шигшээ тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулахад 244 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Сүхбаатар дүүрэг алт-21, мөнгө-19, хүрэл 21 медалийг тус тус хүртэж улсын хэмжээнд ДЭД байрт шалгарсан. | |
| 23 | НХТЖҮЧ - 3.5.3 НЗДҮАХ- 2.2.1 ХАХТ - 2.2.1.4, ДЗДҮАХ- 2.3.4 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-д иргэдийг хамруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | "Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-д 6061 хүн хамрагдсан. А-950, В-2059, С-1493, D-877, F-353 | Томоохон зах, худалдааны төвийн ажилтнуудыг хамруулан оролцогчдын тоог 500 аар нэмэгдүүлж, үнэлгээний чанарыг ахиулсан байна. | | Дүүргийн төсөв | НХХ | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгуулж, дэргэдэх 16 хэлтэс, 10 ерөнхий боловсролын сургууль, 27 СӨББайгууллага, нийт 53 байгууллагын 12,851 хүнээс сорил авч ажилласан. Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2023 оны 11 дүгээр сарын 16,17-ны өдөр Иргэдийн бие бялдрын чийрэгжилтийн ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судалгаа, сорилыг 18-64 насны нийт 250 ажилтан, албан хаагч, иргэдээс авлаа. | 100% |
| 24 | | Спорт өдөрлөг, явган аялал зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, оролцогчдын тоо | "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аянд 19721 иргэн, "Алхацгаая-Гүйцгээе" аянд 1450 | Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын дунд спорт явган аялал зохион байгуулна. | 8.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгийн дунд Цэнгэг агаар өдөрлөгийг 4 удаа зохион байгуулж, нийт 850 гаруй | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гаруй иргэн тус тус хамрагдсан. | | | | | ажилтан, албан хаагч хамрагдсан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд Цаг гаргая биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж, 34 байгууллагын 5100 иргэн хамрагдсан.<br><br>Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/71 дүгээр тушаалын дагуу Алхацгаая гүйцгээе нийтийн алхалтыг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын 126 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулж, 6,993,000 төгрөгийг зарцууллаа.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/294 дүгээр захирамжаар Алхацгаая гүйцгээе хөдөлгөөнийг 2023 оны 05 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд сар бүрийн 2,4 дэх долоо хоногийн Бямба гарагт өрнүүлэн, 29,500,000 төгрөг зарцуулж, 20 хорооны 2300 ажилтан албан хаагчид, иргэд оролцсон. Мөн дүүргийн төрийн 91 байгууллагад тус аянг өрнүүлэх тухай албан бичиг, мэдээлэл хүргэн ажилласан.<br>2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн Ахмадын хорооноос зохион байгуулсан Эрүүл мэнд явган аялалд 9 дүүргийн ахмадууд Ургах наран хорооллоос Баянзүрх хайрханд явган аялал хийж, Сүхбаатар дүүргийн "Хөх тэнгэр" явган аяллын баг 3-р байранд орлоо. | |
| 25 | | "УБ Марафон" олон улсын гүйлтийн тэмцээнд | Оролцогчдын тоо | Улаанбаатар марафон-2022 өдөрлөгт 46 байгууллагын 2000 | Байгууллага аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, | 1.0 | Дүүргийн төсөв | НХХ | "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлт 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж, 3100 гаруй иргэд, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүүргийн иргэдийг бүртгэж оролцуулна. | | гаруй иргэн оролцсон. | оролцогчдын тоог 2200-д хүргэнэ. | | | | тамирчид хамрагдсан. Мөн Автомашингүй өдөрлөгөөр иргэдийн дунд дартс, шатрын тэмцээн зохион байгуулж, эрэгтэй, эмэгтэй багийн 141 иргэн хамрагдаж, шалгарсан багуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулсан. | |
| 26 | НХТЖҮЧ - 3.5.2 НЗДҮАХ-2.2.3 ХАХТ - 2.2.3.2, ДЗДҮАХ-2.3.5 | "Спорт цогцолбор"-ын барилгын ажлын хүндрэлтэй асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарч, холбогдох байгууллагуудад албан хүсэлтийг хүргүүлж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, ажлын явц | А блокын ажил эхлээгүй, Б блокын 800 хүний суудалтай, спорт заалны 3 давхар карказ угсарсан, В блокын фитнес, жижиг заал, албан конторын өрөөнүүдийн карказ угсарсан. 2022 онд 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн боловч гүйцэтгэгч компани дахин магадлангаар орох санал ирүүлж, захиалагч байгууллага Биеийн тамир спортын улсын хороо Сангийн яаманд гүйцэтгэгч байгууллагыг өөрчлөх санал хүргүүлсэн. Барилгын ажил зогссон, 40%-ийн гүйцэтгэлтэй. | Гүйцэтгэгч байгууллагыг өөрчлөх асуудлыг шийдвэрлүүлнэ. | | Улсын төсөв | НХХ | Спорт цогцолборын барилгын ажил 3 блокоос бүрдэх бөгөөд А блокын ажил эхлээгүй, Б блокийн 800 хүний суудалтай, спорт заалны 3 давхар каркас угсарсан, В блокийн фитнес, жижиг заал, албан конторын өрөөнүүдийн каркас угсарсан. 2022 онд 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн боловч гүйцэтгэгч компани дахин магадлангаар орох санал ирүүлж, захиалагч байгууллага Биеийн тамир спортын улсын хороо Сангийн яаманд гүйцэтгэгч байгууллагыг өөрчлөх санал хүргүүлсэн. Барилгын ажил зогссон, 40%-ийн гүйцэтгэлтэй. 2023 оны улсын төсөвт санхүүжилт төсөвлөөгүй, МУИС-тай газрын маргаантай бөгөөд угсарсан каркас нь нуралт, суулт өгөх эрсдэлд орж, магадлангын шийдвэр одоог хүртэл гараагүй, тодорхойгүй байна. | 40% |
| 1.4 (2.4) Сургалтын чанарыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | НЗДҮАХ-2.3.2 ХАХТ-2.3.2.2 ДЗДҮАХ - 2.4.1 | Төрийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтэд үндэслэн зураг, төсөв боловсруулж дахин төлөвлөх, өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | Хөрөнгө оруулалтын дүнгээр | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 159-р сургууль, 54, 216, 281-р цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 1280 суудал, 680 орны хүчин чадлаар нэмэгдүүлсэн. | 12, 16 дугаар хороонд шинэ сургууль, 149 дүгээр цэцэрлэгийг ашиглалтанд оруулна. 31 дүгээр сургууль, 243, Шинэ 50 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | 4,970.5 | Улс, нийслэл | ТГУХ | 12, 16 дугаар хороонд шинэ сургууль, 149 дүгээр цэцэрлэг, 31 дүгээр сургууль, 243, Шинэ 50 ортой цэцэрлэгийн барилгын ажил Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 115 дугаар тогтоолоор 2024 онд дамжин хэрэгжихээр батлагдсан. | 100% |
| 28 | МУХЖТ-1.1.1, НХТЖҮЧ-2.1.1 НЗДҮАХ-2.3.1 ХАХТ - 2.3.1.2 ДЗДҮАХ - 2.4.3 | Дүүргийн шилдэг боловсролын байгууллага, багш, ажилтныг шалгаруулах, ажлын үр дүнг тооцох, дэмжих ажлыг зохион байгуулна. | Шилдэг байгууллага, багш, ажилтны тоо, санхүүжилтийн хэмжээ | 1 цэцэрлэг, 3 сургууль, 67 багш, ажилтан | 2 цэцэрлэг, 2 сургууль, 70 багш, ажилтныг шагнаж урамшуулах, бодит дэмжлэг үзүүлнэ. | 380.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дэлхийн багш нарын 29, Монголын багш нарын 57 дахь өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны А/416 дугаар захирамжаар 238,0 сая төгрөгний санхүүжилтээр шилдэг боловсролын байгууллага, багш, ажилтны ажлын үр дүнг тооцох, дэмжих ажлыг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд дүүргийн удирдлагууд сургууль, цэцэрлэгийн багш ажилтнуудын төлөөлөл 1300 хүн оролцож, мэргэжлийн ур чадварын болон спортын уралдаан наадмуудын шилдгүүд, 2022-2023 оны хичээлийн жилийн шилдэг авъясыг хөгжүүлэгч, бүтээлч, оюуныг тэтгэгч, хүүхдийн хөгжлийг дэмжигч, сургалтын технологийг туршин хэрэгжүүлэгч багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйч нарын 193 багш, ажилтанд өргөмжлөл, мөнгөн шагналыг гардуулсан. Мөн Засаг даргын 2020-2024 оны "Хөгжилд хөтлөх Сүхбаатар дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тусгасан "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2 багшийн орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. | |
| 29 | | Багш, ажилтнуудын ёс зүйн ур чадварыг хөгжүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | Хамрагдсан багш, ажилтны тоо, зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт хувь | Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ, байгууллагын соёлд цахим засаглалын нөлөө сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, 291 багш, ажилтан хамруулсан. | Сургууль, цэцэрлэгийн орон тооны бус ёс зүйн зөвлөлийн 488 багш, ажилтан | | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/83 дугаар захирамжаар Даймонд майнд Хүний хөгжлийн академитай хамтран төрийн өмчийн 26 сургуулийн 1639 багш, 36 цэцэрлэгийн 439 багшид Амжилттай өдрийг хэрхэн бүтээх вэ?, PPT бэлтгэх арга зүй, Хүн хоорондын ялгаа ба диск, Багш болон удирдлагын ёс зүй, Ар гэр, амьдралын тойрог, 21-р зууны ур чадвар сэдвээр 3 цагийн цахим сургалт, 63 удирдлагуудад танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан. Нийт 502 багш, ажилтны ёс зүй, хувь хүний хөгжил, ур чадварыг хөгжүүлсэн. | 100% |
| 1.5 (2.5) Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | | | | |
| 30 | МУХЖТ-1.1.6, НХТЖҮЧ 2.4, НХТЖҮЧ-6.4.1 НЗДҮАХ-5.1.2 ХАХТ-5.1.2.3 НЗДҮАХ-2.3.3 ХАХТ-2.3.3.1 ДЗДҮАХ-2.5.1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан үүсгэж баяжуулна. | Тоо хэмжээ, талбайн хэмжээ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбайн мэдээллийн санг үүсгэсэн. 1-20 дугаар хорооны 2320 ААНБ-аар Хог хаягдлын нэгдсэн | Нийт тохижилтын ажлыг мэдээллийн санд 100 хувь оруулна | | | ТНААХ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 186 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийн төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбай, 1-20 дугаар хорооны 2320 ААНБ-аар Хог хаягдлын нэгдсэн мэдээлэл, 7142ширхэг гэрэлтүүлэг, 1016 ширхэг камержуулалтаар мэдээллийн нэгдсэн санг үүсгээд байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийн санг үүсгэсэн. | | | | | | |
| 31 | | Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт засвар үйлчилгээ, тохижилт, бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлнэ. | Хөрөнгө оруулалтын дүнгээр | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 11, 31, 35 дугаар сургууль, Насан туршийн боловсролын төв, 14, 42, 159, 160, 166, 171, 175, 216 дугаар цэцэрлэгүүдэд нийт 1,734,197.8 мянган төгрөгөөр дээвэр, фасад, сантехник, цахилгаан, дотор засварын ажлын 15 төсөл, арга хэмжээг 100% бүрэн хэрэгжүүлж, 6 сургууль, 8 цэцэрлэгт хүүхдийн суралцах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн. 1 тэрбум төгрөгөөр сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай тавилга, хэрэгслээр хангаж ажилласан. | ЕБС, СӨБ-ын засвар тохижилтын шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | 1,586.6 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 248-р цэцэрлэгийг дулааны шугамд холбох, 31-р сургуулийн гадна талбайн тохижилт хийх, 42-р цэцэрлэгийн В байрны дээвэр засвар, 159-р сургуулийн хашаа барих, 143-р цэцэрлэгийн А, Б байрны дээвэр, ус зайлуулах, гадна, дотор цахилгаан, хүчит төхөөрөмж, гэрэлтүүлэг холбоо дохиоллын засвар, шинэчлэл хийх нийт 1,584.3 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 3 цэцэрлэг, 2 сургуулийн орчин нөхцөлийг сайжруулсан. | 100% |
| 32 | ДЗДҮАХ 2.5.2 | Гэрээс сургууль хүртэлх өндөр эрсдэлтэй бүсийн судалгаа гаргаж, үе шаттайгаар гэрэлтүүлэг, камержуулалт, тохижилт хийнэ. | Хэрэгжилтийн хувь, хөрөнгө оруулалтын хэмжээ | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийснээс 7 сургууль их эрсдэлтэй үнэлэгдсэн. | Эрдмийн хөтөч цогцолбор (58), 71-р сургуулийн сурагчдын гэртээ харих замын эрсдлийн үнэлгээ хийгдэж, аюулгүй байдлыг хангасан байна. | 200.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Эрдмийн хөтөч цогцолбор (58), 71-р сургууль орчимын гэрэлтүүлэггүй гудамжинд гэрэлтүүлэг, камержуулалт хийхээр судалгаа хийгдсэн. 2024 оны төсөвт тусгахаар ажиллаж байна. | 100% |
| 33 | ДЗДҮАХ-2.5.4 | Номын баяр, өдөрлөг, арга хэмжээнд иргэдийг өргөнөөр оролцуулж, зохиолч, номын худалдаа эрхлэгчидтэй | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Олон улсын "Номын баяр 2022" өдөрлөгт дүүргийн 22 зохиолч, орчуулагч, 8 номын худалдаа эрхлэгч болон иргэд оролцлоо. | Номын баяр, өдөрлөг, арга хэмжээнд 1-20 дугаар хорооны иргэд, зохиолч, номын худалдаа эрхлэгчдийг оролцуулна. | 2.0 | Дүүргийн төсөв | НХХ | Соёлын яам, нийслэлийн Соёл урлагийн газар, Номын соёлт ертөнц ТББ хамтран "Үндэсний бичиг соёл, номын 33, 34 дэх удаагийн баяр" өдөрлөгийг Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 05 дугаар сарын 26-28, 09 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулж, номын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллана. | | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар 3,5,12,16 дугаар хороодын номын буланд 100 ширхэг ном олгож, баяжилт хийсэн. | | | | | танилцуулга, худалдаа, гэрэл зургийн үзэсгэлэн худалдаа, зохиолч уншигчдын уулзалт, уран зохиолын уншлага, сонсдог номын цаг, яруу найргийн өдөрлөг зэрэг бүх насны уншигчдад зориулсан соёл, урлагийн олон талт арга хэмжээнд иргэдийг өргөнөөр оролцуулсан. 2023 онд 58 дугаар сургуулийн номын сангаар нийт 850 хүүхэд, багш, ажилтан үйлчлүүлсэн. | |
| 34 | НХТЖҮЧ - 2.4.3 НЗДҮАХ-2.3.7 ХАХТ-2.3.7.2 ДЗДҮАХ-2.5.3 | Сандал хогийн сав байршуулна. | Тоо хэмжээ | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 256 ширхэг сандал 150ш хогийн сав байршуулсан. | Нийтийн эзэмшлийн талбайд 240 сандал, 250 хогийн сав байршуулсан байна. | 200.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн Засаг даргын А/319, А/322 дугаар захирамжаар 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайд өнгө үзэмж муудсан шаардлага хангахгүй болсон хогийн савыг сольж 120 ширхэг хогийн савыг байршуулах ажлыг зохион байгуулсан. Мөн нийтийн эзэмшлийн гудамж талбайд 238 ширхэг сандал, 238 ширхэг хогийн сав худалдан авахаар өсөн үржих констракшн ххк-тай гэрээ байгуулан нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан болно. | 100% |
| 35 | МУХЖТ-1.1.6, НЗДҮАХ-2.3.3 ХАХТ-2.3.3.2, ДЗДҮАХ-2.5.5 | Ерөнхий боловсролын 9-12-р ангийн сурагчдын дунд "Ирээдүйн ээзд" мэргэжил сонголтын аян өрнүүлнэ. | Хамрагдсан хүүхдийн тоо | "Ирээдүйн ээзд" аяны хүрээнд ерөнхий боловсролын 42 сургуулийн 9-12 дугаар ангийн 2000 сурагчдад мэргэжил сонгох зөвлөгөө, мэдээлэл өгсөн. | Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 3000 сурагчдыг хамруулна. | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | "Ирээдүйн ээзд" мэргэжил сонголтын аяныг ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийн ахлах ангийн 2848 сурагчдын дунд зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын дунд Паралимпийн үйл ажиллагааг сурталчлах, алдар цолтой тамирчидтай уулзалт, ярилцлага болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, сургалтад 29 дүгээр сургуулийн 30, 25 дугаар сургуулийн оюуны бэрхшээлтэй 5, сэргээн засах үндэсний төвийн 13 хүүхэд, нийт 48 хүүхэд оролцсон. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | МУХЖТ-1.1.6, НЗДҮАХ-2.3.3 ХАХТ-2.3.3.2, ДЗДҮАХ-2.5.6 | Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг чадавхжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны А/327-р захирамжаар ерөнхий боловсролын 19 сургуульд сэтгэл зүйчийн орон тоог баталж, 12 сэтгэл зүйч ажиллаж байна. | 19 сэтгэл зүйчийг чадавхжуулсан байна. | 15.0 | Дүүргийн төсөв | НХХ | 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр төрийн болон төрийн бус өмчийн 49 сургуулийн "Хүүхэд хамгааллын баг"-ийг чадавхжуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад сургуулийн 22 сэтгэл зүйчид хамрагдсан. Дүүргийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн Ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр боловсролын байгууллагын сэтгэл зүйчидтэй уулзаж, арга зүйн зөвлөгөө өгсөн. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 125 иргэдэд бүлгийн, 16 иргэнд ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлсэн. Японы хүүхдийг ивээх сантай хамтран 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн сэтгэл зүйчдийн "Супервишн" 4 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд 26 сэтгэл зүйч ажиллаж байна. | 95% |
| 37 | НЗДҮАХ-2.3.6 ХАХТ-2.3.6.2 ДЗДҮАХ-2.5.7 | Цахим удирдлагын системийг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Google Education Suite, Microsoft One Drive зэрэг цахим талбарыг 23 сургууль ашиглаж, нийт 1228 багш, 23101 сурагчдын цахим сургалтын орчин бүрдсэн. | 3200 багш, 43000 сурагчийг хамруулна. | | Дүүргийн төсөв | НХХ | -Цэцэрлэгийн элсэлт, 1 дүгээр ангийн элсэлтийг e-mongolia болон parent.edu mn системээр зохион байгуулж, цэцэрлэгт 10137, 1 дүгээр ангид 3955 хүүхдийн хүсэлтийг хүлээн авч элсүүлсэн. -Боловсролын салбарын мэдээллийн системийн esis.edu.mn-байгууллагын бүртгэл, статистик, хоол үйлдвэрлэл, ирц, fin.esis.edu.mn-цахим төсөв, medle.mn, esan.mn цахим хичээл, сургалтын материал, сурах бичиг, parent.edu.mn-эцэг эхийн систем, bagsh.esis.edu.mn-багшийн систем зэрэг нийт цахим удирдлагын 6 системийг 49 ерөнхий боловсролын сургууль, 1 насан туршийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | боловсролын төв, 60 цэцэрлэгт бүрэн нэвтрүүлж, ашиглаж байна.<br>-https://medle.mn/ сайтад тус дүүргийн багш нар 329 цахим хичээл байршуулж, 70 хичээл нэмж байршуулах эрх авсан.<br>-Боловсролын салбарын мэдээллийн системд 60 цэцэрлэгийн 10137 хүүхэд, 1503 багш ажилтан, 49 сургууль, 1 насан туршийн боловсролын төвийн 47017 сурагч, 3618 багш ажилтны мэдээлэл бүртгэгдэж, тухай бүрт шинэчлэлт өөрчлөлтийг хийж байна. | |
| 38 | МУХЖТ-1.1.7 НХТЖҮЧ-2.4.2 НЗДҮАХ-2.3.5 НХЖТ-1.3.16 ДЗДҮАХ-2.5.8 | БСШУЯ-аас хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн "Загвар" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Сургуулийн тоо | БЕГ-аас санхүүжилтийг шийдвэрлэж, хоол үйлдвэрлэлээ бие даан явуулж буй 6 сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн судалгааг гаргасан. | 1-3 сургуулийн гал тогооны хүчин чадлыг нэмэгдүүлж, стандарт шаардлагад нийцүүлнэ. | 60.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн Загвар төслийн хүрээнд 2, 45, 159 дүгээр сургуулиудын гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж, жижиг хэрэгслийг худалдан авахад шаардагдах нийт 44,848,000 төгрөгийн санхүүжилтийг дүүргийн Засаг даргын А/324, А/343, А/471 захирамжуудаар тус тус шийдвэрлүүлж, сургуулиудын худалдан авалтын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| 39 | ДЗДҮАХ-2.5.9 | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад хог хаягдлын хор уршиг, түүнийг хэрхэн бууруулах, дахин ашиглах, хогийг ангилан ялгах дадал зуршлыг бий болгох талаар сургалт, сурталчилгаа хийж, таниулах ажлыг зохион байгуулна. | Сургалт, сурталчилгааны тоо | Ерөнхий боловсролын 2 сургууль 113 хүүхдэд сургалт зохион байгуулсан. | 2 удаагийн сургалтад Ерөнхий боловсролын 10 сургуулийн 500 хүүхдийг хамруулна. | | | ТНААХ | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-н сургалтын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр гүйцэтгэх захирлаар батлуулсан. Сургалтын төлөвлөгөөнд Дотоод сургалт, Ганцаарчилсан болон зайлшгүй хэрэгцээт сургалт, Гадаад сургалтыг тус тус тусгаж өгсөн. Төлөвлөгөөний дагуу 2023 оны 3 дугаар улирлын байдлаар сургуулийн өмнөх насны хүүхдүүд болон ерөнхий боловсролын нийт 556 сурагчдад сургалт сурталчилгааг явуулж шаардлагатай гарын авлагаар хангаж ажилласан.<br>Сургалтанд хамрагдсан байгууллага: | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны 217 дугаар цэцэрлэгийн нийт 45 хүүхдүүдэд 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны 131 дүгээр ерөнхий боловсралын 4 ангийн 235 сурагч, 3 ангийн 234 сурагч нийт 69 сурагчдад 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны 166 дугаар цэцэрлэгийн ахлах болон дунд бүлгийн нийт 42 сурагчдад 2023 оны 05 дугаар сарын 8-ний өдөр тус тус сургалтыг зохион байгуулсан болно. Сургалтанд хамрагдсан сурагчидад хүүхдүүдийн насанд тохирсон гарын авлага тараах материалыг бэлтгэн олгосон. | |
| 40 | ДЗДҮАХ-2.5.10 | Эко сургууль, ногоон цэцэрлэг бий болгох аяныг өрнүүлнэ. | Хамрах хүрээ | Шинээр | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд болзолт уралдаан зарлана. | | | ТНААХ | Улсын хэмжээнд Эко сургууль, ногоон цэцэрлэг бий болгох аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх сургууль цэцэрлэгийг Олон улсын эко сургууль хөтөлбөрт хамрагдах талаар болзолт уралдаан зарлаж Ногоон туг өргөмжлөлөөр 40, 130, 159, 166-р цэцэрлэг, Хүрэл гэрэгэ өргөмжлөлөөр 42, 51, 216-р цэцэрлэг хүртэж амжилттай оролцоод байна. | 100% |
| 1.6 (2.6) Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн чиглүүлж, тусламж үйлчилгээг сайжруулна | | | | | | | | | | |
| 75 | ДЗДҮАХ-3.1.6 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тухайн оны дүүргийн төсвийн төслийг олон нийтэд танилцуулах зорилгоор нийтийн сонсголыг зохион байгуулна. | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тухайн оны дүүргийн төсвийн төслийн талаар олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна. | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажил болон тухайн оны дүүргийн төсвийн төсөлтэй танилцуулан ажилласан. | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажил болон тухайн оны дүүргийн төсвийн төсөлтэй танилцах төсвийн ил тод байдал хангагдсан байна. | | | СТСХ | Иргэдийн Төлөөлөгчдын хурлын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай" 7/35 дугаар тогтоолоор дүүргийн хөрөнгө оруулалтаар 53,727,194.8 мянган төгрөгийн өртөг бүхий 61 төсөл арга хэмжээ батлагдсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 1,210,623,6 мянган төгрөгийн өртөг бүхий 13 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагын комисс ажиллуулах тухай албан бичгийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/228 тоот захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажил хүлээн авах комисс нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөлт арга хэмжээг санхүүжүүлж байна. Дүүргийн хөрөнгө оруулалтын батлагдсан 61 төсөл арга хэмжээнээс 51 төсөл арга хэмжээ хэрэгжиж 33,831,519,6 төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт олгогдоод байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 12 төсөл арга хэмжээний 1,202,036,2 төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт олгогдоод байна. | 90% |
| Гурав. Засаглалын бодлого /Нээлттэй, хариуцлагатай сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | |
| 3.1 (4.1) Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай ил тод хүргэнэ. | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 76 | ДЗДҮАХ-4.1.1 | Хөдөлгөөнт оффис ажиллах журмын дагуу хэлтэс, нэгжүүд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, тайлагнах, боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллана. | 1-20 дугаар хороо | Засаг дарга болон Засаг даргын орлогч, зөвлөхөөр ахлуулсан 2 баг хагас жил тутам хороодод ажиллаж байна. | 1-20 дугаар хороонд ажиллаж иргэд, ААНБ-н албан хаагчид хамрагдсан байна. | 5.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Дүүргийн Засаг дарга Х.Болормаа, ТГУХ-ийн дарга М.Бямбасүрэн, ТНААХ-ийн дарга Т.Эдмон, ГЗБА-ны дарга Э.Зоригоо нарын бүрэлдэхүүнтэй баг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн батлагдсан хуваарийн дагуу хороодод ажиллаж, 2020-2023 оны хугацаанд хийж хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаарх болон нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх гарааш буулгалт, ТҮЦ нүүлгэлт зэрэг ажлын талаар мэдээлэл өгч, иргэдийн асуултад хариулт өгч ажиллалаа.<br>7,8,9 дүгээр саруудад Сүхбаатар дүүргийн хэмжээнд үерийн дараах сэргээн босголтын ажлууд үерийн хор уршгийг арилгах, сэргээн засварлах, ариутган халдваргүйжүүлэх, цаашид үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах,<br>Тоосгон гараашийг буулгаж, газрыг чөлөөлөх, чөлөөлөлт хийсэн талбайд иргэдийн саналын дагуу тохижилт, бүтээн байгуулалт хийх<br>Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг бууруулах хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлүүдээр дүүргийн Засаг дарга, холбогдох албаны удирдлага, мэргэжилтнүүдтэй хамтран хороодод тухай бүр газар дээр нь очиж ажиллан 10 гаруй удаагийн уулзалт хийж, иргэдийн санал гомдлын дагуу асуудлуудыг шийдвэрлэн ажиллалаа | 100% |
| 77 | ДЗДҮАХ-4.1.2 | Хороодын Иргэний танхимд тогтмол зохион | Хамрагдсан иргэдийн тоо | Хорооны үйл ажиллагаанд залуучуудын | Хороо тус бүрт шаардлагатай зардлыг | 20.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Тайлант хугацаанд хороодын Иргэний танхимуудад тогтмол зохион байгуулагддаг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулагддаг үйл ажиллагаанд иргэд, хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | | оролцоо хангалтгүй, төсөв байхгүй тул тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжгүй. | санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн байна. | | | | ахмадуудын хийн дасгал, нийтийн бүжиг, монгол бичгийн дугуйлан, тэмцээн, уралдаан зэрэг 30 орчим төрлийн үйл ажиллагаануудад давхардсан тоогоор 3700 гаруй иргэд хамрагдаад байна.<br>Төрийн болон ТББ-уудтай хамтарсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зэрэг давхардсан тоогоор 200 гаруй үйл ажиллагаануудад 12000 гаруй иргэн хамрагдаж мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна.<br>Дүүргийн ЗДТГ-ын даргын тушаалаар хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардал 3.0 сая төгрөгийг хороо тус бүрт шилжүүлж үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа. | |
| 78 | ДЗДҮАХ-4.1.3 | Дэргэдэх хэлтэс, албадын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын шийдвэрлэнэ. | Хөрөнгө оруулалтын дүнгээр | Шинээр | Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна. | 713.7 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дэргэдэх хэлтэс, албадын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай барилга угсралт, засварын ажил, материаллаг бааз бэхжүүлэх нийт 713.7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.01.26-ны өдрийн 6/142, 2023.01.30-ны өдрийн 6/194, 2023.03.10-ны өдрийн 6/381 дугаартай албан бичгээр тус тус худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Худалдан авалтын захиалгын гүйцэтгэл 100%.<br>Үүнээс 671.4 сая төгрөгийн 4 төсөлд гэрээ байгуулан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. 42,3 сая төгрөгийн 1 төсөл худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. | 94% |
| 79 | ДЗДҮАХ-4.1.4 | Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны | Хувиар | Дүүргийн Засаг дарга, ЗДТГ-аас хэрэгжүүлж байгаа | Иргэдэд төрийн үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт | 50.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, түүний биелэлтийг хангах ажлын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөрийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн боломжит сувгуудыг ашиглан иргэд, олон нийтэд тогтмол сурталчилна. | | үйл ажиллагааны мэдээ мэдээллийг sbd.gov.mn цахим хуудас, Засаг даргын Тамгын газар болон 1-20 дугаар хорооны 23 пэйж хуудас /Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, Сүхбаатар дүүргийн-Шуурхай штаб/, ТВ2 телевизээр тус тус иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. | болон Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй бодлого, үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг шинэлэг хэлбэрээр олон нийтэд хүргэж ажиллана. | | | | хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагаа бүрийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээг ашиглан олон нийтэд сурталчлан ажиллаж байна.Тайлант хугацаанд 304 мэдээ бэлтгэн байгууллагын албан ёсны www.sbd.gov.mn вэб сайт, Хөхүүгийн Болормаа, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар, Сүхбаатар дүүргийн Шуурхай штаб, Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Түмэнд түгээнэ, Нийслэл Улаанбаатар болон 20 хороо тус бүрийн пейж хуудсуудаар агуулга давхардсан тоогоор 10000 гаруй удаа иргэд, олон нийтэд мэдээлсэн байна. Хийж хэрэгжүүлж буй ажлаа иргэдэд хүргэх, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Арилжааны телевизүүдийн холбоо, дүрс бичлэгийн студитэй хамтран ажиллаж, мэдээ мэдээллээ дамжуулж ажилласан. Онцолбол, Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалт, Газрын зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд хийгдэж буй чөлөөлөлтийн ажлын явц, хоггүй хотын төлөө аяны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, ил задгай тамхины иш хаяулахгүй байх уриалга, зөв хандлага жишиг тогтоох нийгмийн сайн сайхны төлөөх ажлуудын зэрэгцээ, байгалийн гамшиг үер усны аюулын үеийн сэрэмжлүүлэг, зөвлөмжүүд, улс, нийслэл, дүүргээс хойшлуулшгүй сэргээн босголтын ажлын хүрээнд зохион байгуулсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг онцолж байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 80 | ДЗДҮАХ-4.1.5 | Төрийн зарим үйлчилгээг хороодод үе шаттайгаар шилжүүлэх ажлыг НЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хэрэгжүүлж, дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Иргэний бүртгэлийн 21 төрлийн лавлагаа, 9 төрлийн бүртгэлийн үйлчилгээг харъяалал харгалзахгүйгээр олгож байна. Нийслэлийн Архивын газраас үзүүлдэг 15 нэр төрлийн үйлчилгээг тус дүүргийн 5,20 дугаар хорооноос үзүүлж байгаа | Хүн ам олонтой алслагдсан хороодын иргэд төрийн зарим үйлчилгээг харъяалал харгалзахгүйгээр авах боломж нөхцөл бүрдэж, дүүргийн бүх хорооноос дээрх зорилтын хүрээнд иргэдээс архивын лавлагааны хүсэлтийг хүлээн авч, иргэнд хариуг олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг эхлүүлнэ. | | Азийн сан НЗДТГ | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс дараах байршлуудад улсын бүртгэлийн үйлчилгээг харъяалал харгалзахгүй үзүүлж байна. Үүнд:<br>-Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын байранд эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ<br>-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Их тойруу" худалдааны төвийн 1 давхарт эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний улсын бүртгэл.<br><br>-8 дугаар хорооны байранд эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний улсын бүртгэл.<br>-3 дугаар хорооны байранд иргэний улсын бүртгэл. -Улаанбаатар их дэлгүүрийн 1 давхарт иргэний улсын бүртгэл.<br>-Улсын клиникийн 1 дүгээр эмнэлгийн 1 давхарт иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг тус тус үзүүлж байна.<br><br>Нийслэлийн Архивын газраас үзүүлдэг 15 нэр төрлийн үйлчилгээг тус дүүргийн 5,20 дугаар хорооноос үзүүлж байгаа бөгөөд нийслэлийн бүх хороодоос дээрх зорилтын хүрээнд иргэдээс архивын лавлагааны хүсэлтийг хүлээн авч, иргэнд хариуг олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болсон байна. Энэ ажлын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр нийслэлийн Архивын газрын Лавлагаа үйлчилгээний хэлтсийн дарга н.Бат-Эрдэнэ хороодын зохион байгуулагч нарт Онлайн лавлагааны системийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ашиглалт, төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримт, төв, төрөлжсөн архивын онцлогийг танилцуулж, нийслэлийн Архивын газраас үзүүлдэг 15 нэр төрлийн лавлагаа, үйлчилгээг хорооноос олгох боломжийн талаар мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөв. | |
| 81 | ДЗДҮАХ-4.1.6 | Албан хаагчдыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 11 албан хаагч хамрагдсан. | 1-с доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | | Дүүргийн төсөв | ТЗУХ | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг НЭГДЬЕ аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн төрийн албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэн сайн мэдэх вэ? сэдэвт мэдлэг сорих тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. Уг тэмцээнд 13 байгууллагын 15 багийн 45 төрийн албан хаагч оролцож, хамгийн өндөр оноо авсан 4 багийг шалгаруулж батламж, мөнгөн шагналаар шагнасан. Тэмцээний үеэр Авлигатай тэмцэх газраас 4 төрлийн сургалтчилгааны материалыг оролцогчдод тарааж, 2 төрлийн видео танилцуулгыг хүргэсэн. Тэмцээнд оролцогчид хуулийн мэдлэгээ дээшлүүлэхээс гадна авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах олон санал, санаачлагыг гаргаж оролцсон нь үр дүнтэй болсон.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн албан хаагчдад хуулийг танилцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нэгж, Тамгын газар, хороодын албан хаагчдад зориулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Сургалтаар Сэтгэлгээний өөрчлөлт, Бүтээмж дээшлүүлэх арга техник, Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулга сэдвээр лекц, семинар орж, төрийн байгууллагаас үйлчилгээ авахад тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг багасгах, арилгах арга замууд сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. | |
| 82 | ДЗДҮАХ-4.1.7 | Эрх зүйн маргаантай асуудлаар хуулийн дагуу дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрыг төлөөлөх ажлыг зохион байгуулна. | Шүүх болон бусад байгууллагад төлөөлсөн, холбогдох баримтыг бүрдүүлсэн тоон үзүүлэлтээр | 2022 оны байдлаар давхардсан тоогоор 130 гаруй удаагийн шүүх хуралд цахимаар болон биеэр оролцож, 63 хэрэгт хариу тайлбар хүргүүлж, 35 удаагийн хүсэлт шийдвэрлүүлж 43 хэрэгт нотлох баримт хүргүүлж, 8 удаагийн газрын үзлэгт явсан. | Байгууллагыг төлөөлөх ажлыг хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна. | | | ХЭЗХ | Тайлант хугацаанд 110 гаруй удаагийн шүүх хуралд биеэр оролцож, 65 хэрэгт хариу тайлбар хүргүүлж, 23 удаагийн хүсэлт шийдвэрлүүлж, 41 хэрэгт нотлох баримт хүргүүлж, 4 удаагийн газрын үзлэгт явсан. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 15 хэрэг, түдгэлзсэн 3 хэрэг, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2 хэрэг УДШ-ийн захиргааны хэргийн танхимд 3 хэрэг маргаан тус тус хянагдаж байна. Тайлангийн хугацаанд захиргааны 37 хэрэг, иргэний 4 хэрэг маргаан бүрэн шийдвэрлэгдсэнээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 27 хэрэг, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан 11 хэрэг, нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон 3 хэрэг, шүүхийн шийдвэр биелүүлэх шатанд 8 хэрэг маргаан байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | | Холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагааг хууль журмын дагуу биелүүлнэ. | Биелүүлсэн шүүхийн шийдвэрийн тоогоор | 2021, 2022 онд дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт холбоотой Захиргааны болон иргэний хэргийн шүүхийн 11 шийдвэрийг биелүүлж, 33,256,318 төгрөгийн хохирол барагдуулсан. | Тухайн жил гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлж ажиллана. | 200.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Тайлант хугацаанд дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт холбогдох 14 хэрэг маргаан байгаагаас 6 хэргийн шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хаасан. Алтан дорнын хүч ХХК-ны нэхэмжлэлтэй хэргийн хохирол Тусгай сангаас 25,000,000 төгрөг, дүүргийн Засаг даргын Тамгын газраас 38,436,425 нийт 63,436,425 төгрөг барагдуулсан. | 90% |
| 84 | ДЗДҮАХ-4.1.8 | Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хувь | 96 хувь нь хамрагдсан | 90-ээс дээш хувь хамрагдсан байна. | | Дүүргийн төсөв | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөг 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан. НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төв болон төрийн бусад байгууллагаас зохион байгуулсан 9 удаагийн сургалтад 176, Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 9 албан хаагч хамрагдсан. Сонгуулийн ерөнхий хороо болон Удирдлагын академийн сургагч багш бэлтгэх сургалтад 12 албан хаагч хамрагдаж төгссөн. Удирдлагын академиас зохион байгуулсан Алсын хараа 2050 сэдэвт богино хугацааны цахим, танхим хосолсон сургалтыг 2023.04.22-23, 2023.05.25-27-ны өдрүүдэд зохион байгуулж, дүүргийн төрийн байгууллагын 200 албан хаагчийг хамруулсан. Мэргэшил дээшлүүлэх магистрын хөтөлбөрт 6, докторын хөтөлбөрт 1 албан хаагч хамрагдаж байна. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн сургалтыг 2023 оны 09 дүгээр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сараас эхлэн 2 сарын хугацаанд 2 ээлжээр зохион байгуулж, анхан шатны сургалтад 72, дунд шатны сургалтад 68 албан хаагч хамрагдсан. Дүүрэгтэй хамтын харилцаатай БНСУ, Япон улс, БНХАУ руу туршлага судлах сургалтад 83 албан хаагч хамрагдсан байна. Хөтөлбөрт албан хаагчид 100 хувь хамрагдаж, төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн. | |
| 85 | | "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хувь | 35 хувь нь хамрагдсан | 50-иас дээш хувь хамрагдсан байна. | 550.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөг 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд байгууллагын Дотоод журмын дагуу 10 албан хаагчид 18,9 сая, 41 албан хаагчид орон сууцтай болох, орон сууцны нөхцөлөө сайжруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлэх, өндөр төлбөртэй эмчилгээ хийлгэхэд нь дэмжлэг үзүүлж 374,7 сая, онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж ажилласан 6 албан хаагчид 20,5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Мөн албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Цасны баяр, 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 5 төрлөөр спортын тэмцээнийг тус тус зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/511 дүгээр захирамжаар 34 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг үнэлж дүгнэн, Маш сайн, Сайн үнэлгээ авсан 123 албан хаагчдад албан тушаалын үндсэн цалингийн 60-80 хувиар урамшуулал олгосон.<br>Монгол Улсын Шадар сайдын тушаалаар 2023.06.07-09-ний өдрүүдэд зохион байгуулсан Стратегийн команд штабын сургуульд амжилттай оролцсон 54 албан хаагчийг албан тушаалын үндсэн цалингаар урамшуулсан.<br>Албан хаагчдыг ая тухтай ажиллах нөхцөлөөр хангах зорилгоор 12-20 дугаар хорооны ажлын албаны өрөөний тохижилт, дээврийн засварын ажил, галч нарын өрөөг тохижуулж засах ажлуудыг хийж, нийт 153,0 сая төгрөг зарцуулсан. | |
| 86 | НХТЖҮЧ-5 3.2<br>НЗДҮАХ-4.1.1<br>НХЖТ-3.1.2<br>ДЗДҮАХ-4.1.9 | Төрийн үйлчилгээний мэдээллийг төвлөрсөн удирдлагатай Онлайн бизнес төвийн ulaanbaatar.mn платформоор дамжуулан худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | Онлайн бизнес төвийн ulaanbaatar.mn системээр үйлчлүүлсэн ААНБ-ын тоо | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ААНБ 736 | 500-гаар нэмэгдүүлнэ. | | | ХХҮХ | НЗД-ын 2021 оны "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/987 дугаар захирамжийн хүрээнд "Онлайн бизнес төв" платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлж, 2023 оны эхний 11 сарын байдлаар 1026 ААНБ, иргэн худалдаа, үйлчилгээ эрхлэхээр хүсэлт илгээснээс 580 хүсэлтийг шийдвэрлэж, 293 хүсэлтийг буцааж, 18 хүсэлтийг татгалзаж, 135 хүсэлт хяналтын шатандаа явж байна. хяналтын шатандаа явж байна.<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйл, Улсын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны байдлаар дүүргийн Засаг даргын А/135, А/184, А/273, А/425, А/488 дугаартай 5 удаагийн захирамжаар нийт-27 аж ахуйн нэгж, иргэнд тамхи худалдах зөвшөөрөл олгон, захирамжийг дүүргийн sbd.gov.mn цахим хуудаст байршуулан, ил тод мэдээллэн ажиллаж байна. | |
| 87 | | Байгууллагын sbd.gov.mn цахим хуудас, e-duureg аппликэйшныг байршуулах биет сервер, цахим хуудасны аюулгүй байдлыг хангагч ssl гэрчилгээ болон чатбот худалдан авах, e-duureg аппликэйшныг App store, Play store-д байршуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Цахим хуудсыг шинэчлэсэн. Ашиглалтад оруулаагүй байгаа. | Цахим хуудас, аппликэйшныг биет серверт байршуулж, хэвийн ажиллагаа хангагдсан байна. | | Дүүргийн төсөв | ТЗУХ | Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу багаж, техник хэрэгсэл тоног төхөөрөмж болон бусад эд хогшилыг тэвчиж болох зардал гэж үзсэний дагуу биет серверийг худалдан аваагүй болно. Цахим хуудасны аюулгүй байдлыг хангагч ssl гэрчилгээг сунгахаар болсон ба e-duureg аппликэйшныг App store, Play store, чатботыг ашиглалтанд оруулж байршуулсан. | 50% |
| 88 | ДЗДҮАХ-4.1.10 | Хороо, ӨЭМТ, цагдаагийн барилгыг шинээр барих болон засварлах ажлыг хэрэгжүүлнэ. | Төсөл арга хэмжээний тоо | 2 дугаар хорооны барилгыг ашиглалтад оруулахад бэлэн болсон. | 17 дугаар хорооны цогцолбор барилгыг барина. | 1,500.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17-р хорооны цогцолбор барилга барих 1.5 тэрбум төгрөгийн барилга угсралтын төсөл, арга хэмжээг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.01.24-ний өдрийн 6/140 дугаартай албан бичгээр дүүргийн худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Төслийг хэрэгжүүлэхээр Дуутын нуруу ХХК-тай 2023.05.31-ний өдөр гэрээ байгуулан, барилга угсралтын ажил 70%-тай баригдаж байгаа бөгөөд төслийг 2024 онд дамжин хэрэгжүүлнэ. | 90% |
| 3.2 (4.2) Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг хангана. | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 89 | ДЗДҮАХ-4.2.1 | Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжүүдийн өргөдөл, гомдлын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэн, шийдвэрлэлтийн мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж, удирдлагуудад танилцуулна. | Зөрчлийн тоо | 2022 оны 10 дугаар сарын байдлаар өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холдбогдох файл хавсаргаагүй нийт 242 зөрчил бүртгэгдсэн байна. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа болон хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо буурсан байна. | | | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийт 6351 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 6208, судлагдаж байгаа 85, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 58 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 98 хувьтай байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 13 цаг 50минут байна. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон бусад зөрчил бүртгэгдсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, зөрчлийг бууруулах чиглэлээр хэлтэс, албадын өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд өдөр тутамд хяналт тавин ажилласан. Мөн дүүргийн харьяа төрийн байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд зохион байгуулж, хяналт шалгалтын мөрөөр хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, зөрчил ихээр бүртгэгдсэн Татварын хэлтсийн албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 9-ний өдөр Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын програмын ашиглалтыг сайжруулах талаар сургалт зохион байгуулсан.<br><br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчил, хугацаа хэтрүүлсэн шийдвэрлэлтийг өнгөрсөн оны | 98% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | мөн үетэй харьцуулбал бүртгэгдсэн зөрчил 1537-гоор буюу 41,4 хувиар, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдлүүдийг 943-аар буюу 94,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна..<br><br>Мөн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоног 8 минутаар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 90 | ДЗДҮАХ-4.2.3 | Дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө гарган, мэргэшүүлэх сургалтад хамруулж, ном гарын авлагаар хангана. | Арга хэмжээний тоо | 7 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 461 байгууллагын 546 албан хаагч хамрагдсан байна. | 3-с доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | 10.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу дүүргийн дэргэдэх хэлтэс, алба, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороодын нийт давхардсан тоогоор 285 байгууллагын 340 албан хаагч сургалтад хамрагдсан байна. | 100% |
| 91 | ДЗДҮАХ-4.2.4 | Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр лицензтэй windows үйлдлийн систем, антивирусийн лицензтэй програмаар хангаж ажиллана. | Компьютерийн тоо | Windows үйлдлийн систем, Антивирус програм хангамжийг trial буюу туршилтын хувилбараар 135 компьютер ашиглаж байна. | 135 компьютерыг албан ёсны лицензтэй Windows үйлдлийн систем, Антивирус програмтай болгосон байна. | 70.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр 135 албан хаагчийн компьютерт албан ёсны лицензтэй Windows үйлдлийн систем, Антивирус , оффис программыг 36,040,950 төгрөгөөр худалдан авч тус тус суулгахаар болгосон. | 100% |
| .3 (4.3) Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | |
| 92 | ДЗДҮАХ-4.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна. | Хувь | 90 хувьтай хэрэгжсэн. | Хэрэгжилт 90-ээс дээш хувьд хүрсэн байна. | 10.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Авлигын эсрэг 2023 оны үйл ажиллагааны 19 заалт бүхий төлөвлөгөө, Сүхбаатар дүүргийн Авлигын эсрэг 2023 оны үйл ажиллагааны 14 заалт бүхий төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж, холбогдох хэлтэс нэгжүүдэд хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны хагас, бүтэн жилээр нэгтгэн, хяналт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шинжилгээ, үнэлгээ хийлгэж, дүгнэлтийн хамт Авлигатай тэмцэх газрын khutulbur.iaac.mn сайтад байршуулж баталгаажуулсан. Төлөвлөгөө 92,1 хувьтай хэрэгжсэн. | |
| 93 | | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн зарим үйлчилгээг цахимжуулах ажлыг зохион байгуулна. | Хувь | 90 хувьтай хэрэгжсэн. | Хэрэгжилт 90-ээс дээш хувьд хүрсэн байна. | | - | ТЗУХ | НЗД-ын 2021 оны "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/987 дугаар захирамжийн хүрээнд "Онлайн бизнес төв" платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлж, 2023 оны эхний 11 сарын байдлаар 1026 ААНБ, иргэн худалдаа, үйлчилгээ эрхлэхээр хүсэлт илгээснээс 580 хүсэлтийг шийдвэрлэж, 293 хүсэлтийг буцааж, 18 хүсэлтийг татгалзаж, 135 хүсэлт хяналтын шатандаа явж байна. хяналтын шатандаа явж байна.<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны байдлаар дүүргийн Засаг даргын А/135, А/184, А/273, А/425, А/488 дугаартай 5 удаагийн захирамжаар нийт-27 аж ахуйн нэгж, иргэнд тамхи худалдах зөвшөөрөл олгон, захирамжийг дүүргийн sbd.gov.mn цахим хуудаст байршуулан, ил тод мэдээллэн ажиллаж байна.<br>Төрийн 35 байгууллагын 440 төрлийн үйлчилгээг цахимаар хүргэх, зөвлөгөө мэдээллээр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хангах ХУРДАН цэгийг тус дүүргийн 10 байршилд байгуулж, төрийн үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай хүргэх боломж нөхцөл бүрдээд байна | |
| 94 | НЗДҮАХ-4.1.4, НХТ-3.1.18, ДЗДҮАХ-4.3.2 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээ | Тус хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 25 удаагийн сургалт, хийж, давхардсан тоогоор 108 орчим хүн хамрагдсан. | 4-өөс доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | 10.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Тус ажлын хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн танилцуулгыг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр дүүргийн 1-20 дугаар хорооны 270 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад танилцуулсан.<br>Цагдаагийн газартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Хамтарсан багийн үйл ажиллагаанд цагдаагийн албан хаагчийн үүрэг оролцоо, Мансуурүүлах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршиг сэдвээр 17 эрх зүйн хөтөч болон цагдаагийн алба хаагчдад сургалт зохион байгуулсан.<br>Хороодын болон Эрх зүйн хөтчийн цахим хуудсанд шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар танилцуулга бэлтгэж, 7 хоног бүр байршуулж хэвшсэн.<br>Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран Өрхийн эрүүл мэндийн төвийн 25 нийгмийн ажилтанд 2023 оны 05 дугаар 11-ний өдөр Захиргааны акт, түүний эрх зүйн үр дагавар сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, хотын стандартыг танилцуулаа.<br>СЕХ-той хамтран "Хариуцлагатай сонсогч" сэдэвт сургалтыг Нийслэлийн ерөнхий боловсролын 2,3,16 дугаар сургуулийн 11,12 дугаар ангийн 75 сурагчдад 2023 оны 04 дүгээр сарын 27, 28-ны өдөр, 09 дүгээр сарын 19, 20-ны өдөр, 10 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа.<br>НЗДТГ, Монголын хуульчдын холбооны 11 өмгөөлөгчтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдөр 15-20 дугаар хороодын 60 гаруй иргэдэд | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.<br>Анхдугаар үндсэн хууль, батлагдсантай холбогдуулан Ерөнхий боловсролын 1, 3, 11, 35 дугаар сургуулиуд болон Насан туршийн боловсролын төв, дүүргийн хороо бүр Үндсэн хуулийг сурталчилж, түүнийг танин мэдүүлэх байнгын булан, өрөөг тохижуулсан. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний танхимд "Монгол Улсын Үндсэн хуулиуд" буланг байгуулж, тохижуулсан.<br>Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүлийн тухай багц хууль тогтоомжийн талаар 2711 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | |
| 95 | | Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжсэн заалтын тоогоор | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, дэргэдэх нэгжийн албан хаагчид, иргэдэд давхардсан тоогоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 170 гаруй иргэд, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан. | Төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувиар хангаж ажиллана. | 10.00 | Дүүргийн төсөв | НХХ | -Жендэрийн Үндэсний хорооны ажлын албатай хамтран хүртээмжтэй төрийн үйлчилгээ, жендэрийн хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчтой ажиллах чадварыг сайжруулах зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр 20 хорооны 35 иргэн, 15 нийгмийн ажилтан, 13 халамжийн ажилтнуудыг хамруулан үйл ажиллагаа зохион байгууллаа. | 80% |
| 96 | НЗДҮАХ-4.2.2, НХТ-3.2.6, ДЗДҮАХ-4.3.2 | Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтын тоог бууруулах зорилгоор | Зохион байгуулсан арга хэмжээ | 2 удаагийн сургалтаар Засаг даргын Тамгын газрын 56 албан хаагчид сургалтад хамрагдсан | 4-өөс доошгүй удаа зохион байгуулна. | 5.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24–ний өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/245 дугаар захирамжаар Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, нэгжийн Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тодорхой ажил зохион байгуулна. | | | | | | | хуульд нийцсэн эсэх, төрийн албан хаагч гэмт хэрэг үйлдэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан.<br>Ажлын хэсгээс гарсан зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас биелэлтийг гаргуулан жилийн эцсийн байдлаар нэгтгэж байна.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/461 дүгээр захирамжаар 10 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Сүхбаатар дүүргийн хороодод ажиллаж буй 300 гаруй гэрээт ажилтнуудад “Алсын хараа–2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн талаарх танилцуулга мэдээлэл хийсэн.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газар, HR mentor group-тай хамтран төрийн албан хаагчийн ёс зүй болон шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар 2023 оны 10 сарын 25-ны өдөр дүүргийн Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, нэгж болон хороодын төрийн захиргааны 100 албан хаагчдад танилцуулга, мэдээлэл хийлээ.<br>Ерөнхий боловсролын 27 сургууль, 36 цэцэрлэгийн удирдлагуудад, Ерөнхий боловсролын 16 дугаар сургууль, МУБИС-ийн харьяа гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, багш, ажилчдад шинээр батлагдсан Боловсролын багц | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хууль болон Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн талаар 2023 оны 11 дүгээр сарын 07, 08-ны өдөр танилцуулга хийсэн. | |
| 97 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн байцаагч нарыг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр ажиллуулна. | Ажилласан Олон нийтийн байцаагчийн тоогоор | 2022 онд 95 Олон нийтийн байцаагчдыг ажиллуулсан. | 100 Олон нийтийн байцаагчдыг ажиллуулна. | 704.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Олон нийтийн байцаагч томилон ажиллуулах тухай Б/03 дугаар захирамжаар 01-20 дугаар хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий 100 олон нийтийн байцаагчийг томилж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр урамшуулан ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар хэв журмын олон нийтийн байцаагчдын урамшуулалд 561,318,188 төгрөгийг олгосон | 100% |
| 98 | | Жагсаал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах мэдэгдлийг бүртгэх ажлыг зохион байгуулж нийтийн хэв журам аюулгүй байдлыг хангана. | Байгууллагад ирсэн мэдэгдлийн тоо, тэдгээрийг шийдвэрлэсэн тоогоор | Жагсаал, цуглаан хийх 53 хүсэлт ирснээс 23 мэдэгдлийг бүртгэн авч, 30 мэдэгдэлд татгалзсан тухай хариуг хүргэсэн. Өлсгөлөн зарлах тухай 1 мэдэгдэл ирүүлснийг хууль тогтоомжийн дагуу хариу өгсөн. | Жагсаал, цуглаан хийх мэдэгдэл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | | - | ХЭЗХ | Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргад хандан жагсаал, цуглаан зохион байгуулах 73 мэдэгдэл ирснээс 28 мэдэгдлийг бүртгэн авч, 2 мэдэгдлийг буцаасан, 43 мэдэгдэлд Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай хуульд заасан үндэслэлээр татгалзсан. Тайлангийн хугацаанд 7 иргэн өлсгөлөн зарлахаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлж, тухайн иргэдийн эрүүл мэндэд хяналт тавих ажиллагаанд эрх зүйн дэмжлэг үзүүлж, дүүргийн Засаг даргыг мэдээллээр хангаж, ажилласан. Жагсаал цуглаан зохион байгуулсан, өлсгөлөн зарласан тохиолдолд төрийн тусгай, захиргааны, үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагааны талаар 3 удаагийн уулзалт зохион байгуулж мэдээлэл солилцон ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 99 | | Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн тайлагнана. | Хяналтад авсан зүйл заалт, хэрэгжилтийн хувиар | 2022 онд дээд газрын 36 тогтоол шийдвэрийн 84 заалтыг хяналтад авч, биелэлтийг нэгтгэн ТГУХ-т мониторинг хийлгэн ажилласан. | Хяналтад авсан зүйл, заалтыг 90 -ээс дээш хувиар хэрэгжүүлнэ | | - | ХЭЗХ | Дээд газрын тогтоол шийдвэрийг Засгийн газрын "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" батлах тухай 2020 оны 246 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтын дагуу хяналтад авч хагас жилийн байдлаар 34 тогтоол, шийдвэрийн 59 заалтын хэрэгжилтийн мэдээллийг холбогдох нэгжээс нэгтгэн авч хагас жилийн биелэлтийг гарган дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээр үнэлгээ хийлгэн ажилласан.<br>11 дүгээр сарын байдлаар нийт 42 тогтоол, шийдвэрийн 61 заалтыг бүртгэж авч холбогдох хэлтэс, албадад танилцуулан ажиллаж байна. | 90% |
| 100 | НХТЖҮЧ-5.3.1, НЗДҮАХ-4.1.1, ХАХТ-4.1.1.4, ДЗДҮАХ-4.3.3 | Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйн талаар сургалт зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын 27 албан хаагчдад сургалт хийсэн. | ЗДТГ-ын болон дэргэдэх хэлтэс, албадын бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан албан хаагчдад 1 удаа сургалт зохион байгуулна. | | Дүүргийн төсөв | ТГУХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвд "Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйн талаар сургалт" зохион байгуулж, дүүргийн тайлан төлөвлөгөө, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан албан хаагчдыг хамруулах талаар санал тавьж, дүүргийн ЗДТГ-ын 5, хороодын 17, дэргэдэх хэлтэс албадын 7 нийт 29 албан хаагчдыг 2023.08.23,25-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны 5-р байранд 2 өдрийн сургалтад хамруулж, сертификаттай болсон. | 100% |
| 101 | | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд болон Засаг даргын дэргэдэх байгууллагуудын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээний ажлын удирдлага, зохион | Шинжилгээ хийх байгууллагын тоо | Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын гүйцэтгэлийн тайланд ХШҮ хийсэн. | Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд болон Засаг даргын дэргэдэх 20 байгууллагын гүйцэтгэлийн тайланд ХШҮ хийнэ. | | Дүүргийн төсөв | ХШҮХ | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу | 95% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулалтын үйл явцад шинжилгээ хийнэ. | | | | | | Нийслэл, дүүргийн 6 төрлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд явцын ХШҮ хийсэн.Дүүргийн хэмжээнд дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд эхний хагас жилийн байдлаар ХШҮ хийсэн. Мөн ДЗДҮАХ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх зорилтуудын хэрэгжилтэд ХШҮ хийж, нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн. ДЗД-ын дэргэдэх байгууллагын удирдлагуудтай байгуулсан хариуцлагын гэрээний хэрэгжилтийн эхний хагас жилийн биелэлтэд ХШҮ хийсэн. Жилийн эцсийн тайлан, биелэлтүүдэд ХШҮ хийх ажил үргэлжилж байна. | |
| 102 | ЗГҮАХ-3.1.11, ДЗДҮАХ-4.3.4 | Улс болон орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллана. | Улс, орон нутгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг хувиар тооцно. | Нийт төсвийн нийлбэр дүнгээр төсвийн орлого 92.4 хувьтай биелүүлсэн. | Хороодын аж ахуйн нэгж байгууллагуудыг хариуцсан 10-15 хүн авч ажиллуулж, дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг сар бүр, төсөв бүрээр, орлогын нэр төрлөөр 100 хувь хангаж биелүүлсэн байна. | 175.0 | Дүүргийн төсөв | ТХ | 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр өссөн дүнгээр:<br>Улсын төсөв – 156%<br>Дүүргийн төсөв – 104%<br>Нийлбэр дүнгээр 130 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр хангаж биелүүлж ажилласан. | 100% |
| 103 | | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар болон галт зэвсгийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх, бүртгэлтэй хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өр барагдуулах ажлыг зохион байгуулна. | ҮХЭХ-ийн албан татвар, галт зэвсгийн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувиар тооцно. | ҮХЭХ-ийн албан татвар, галт зэвсгийн албан татварын төсвийн орлого нийлбэр дүнгээр 92.43 хувьтай биелүүлсэн. | Татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдэж төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажиллана. | 6.5 | Дүүргийн төсөв | ТХ | 1. Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газраас үйлчилгээний, оффисын, автозогсоолын зориулалт бүхий 3861 өмчлөгчийн 3169 үл хөдлөх эд хөрөнгийн судалгаа ирүүлсэн. Тус судалгааг татварын удирдлагын нэгдсэн системтэй тулгалт хийхэд 1857 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэгдэж татвар ногдсон, 1621 өмчлөгчийн 1058 хөрөнгө бүртгэлгүй байсан. Хэлтсийн даргын 2 удаагийн удирдамжит ажлын хүрээнд дараахь ажилбаруудыг хийж байна. Нийт бүртгэгдвэл зохих 1058 хөрөнгөөс бүртгүүлсэн 143 аж ахуйн нэгжийн 4,283,208.9 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | мянган төгрөг, 280 иргэний 1,145,171.38 мянган төгрөг нийт 423 татвар төлөгчийн 5,428,380.37 мянган төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг ногдуулж, татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэсэн байна. 9 татвар төлөгч бүртгүүлэхээр материал ирүүлж, 129 татвар төлөгчид мэдэгдэл хуудас хүргүүлэн, үлдсэн 468 хөрөнгөд тодруулга хийж мэдэгдэл хүргүүлэн бүртгүүлэх ажилбар хийн ажиллаж байна.<br>2023 онд нийт 4901 татвар төлөгчийн 7587 үл хөдлөх эд хөрөнгөд 29,586,527.1 мянган төгрөгийн албан татвар ногдуулж 10,340,134.1 мянган төгрөгийн татвар төвлөрүүлсэн байна.<br>2. Галт зэвсгийн төрлөөр 2023.09.04-ний өдрийн байдлаар дүүргийн төсөвт өссөнөөр 46,800.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 35,415.0 мянган төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 76 хувьтай байна. Шинэчилсэн бүртгэлээр 45 иргэн, 12 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж ажилласан. ТУНС-д давхар буюу илүү бүртгэлтэй нэг төрлийн галт зэвсгийн нэршлийн хувьд өөр өөр байдлаар бүртгэгдсэн 78 галт зэвсгийн мэдээллийг засварласан. Татварын алба хооронд шилжүүлэх ажлын хүрээнд 23 татвар төлөгчийн 32 галт зэвсгийн татварын өрийг төлүүлсэн. Татварын удирдлагын нэгдсэн системийн хөрөнгийн бүртгэлийг тулгахад мэдээлэл дутуу, зөрүүдтэй бүртгэгдсэн, бүртгэл, ногдол давхардсан 86 галт зэвсгийг татварын удирдлагын нэгдсэн системээс хасалт хийж ажилласан. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 104 | | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нэлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ. | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг барагдуулж гүйцэтгэлийг хувиар тооцно | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 100 хувь биелүүлсэн | Хууль тогтоомжийн дагуу Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажиллана | 4.0 | Дүүргийн төсөв | ТХ | Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийлбэр дүнгээр 1,928,795,000 мянган төгрөгийн төлөвлөгөөнөөс 2,026,894,141 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. | 100% |
| 105 | | Газрын төлбөрийг хураан барагдуулах ажлыг зохион байгуулна. | Газрын төлбөрийг хураан барагдуулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хувиар тооцно | Газрын төлбөрийг 90.25 хувьтай биелүүлсэн | Газрын төлбөрийг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажиллах | 5.0 | Дүүргийн төсөв | ТХ | Иргэний газрын эрх борлуулсны орлогын албан татварын төлөвлөгөө өссөн дүнгээр 1,871,899.0 мянган төгрөг бөгөөд 2023 оны 09 сарын 04-ний өдрийн байдлаар өссөн гүйцэтгэл нь 1,121,975.0 мянган төгрөг буюу 60 хувьтай, Газрын төлбөрийн төлөвлөгөө өссөн дүнгээр 3,731,891.0 мянган төгрөг бөгөөд өссөн гүйцэтгэл нь 2,097,592.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. | 100% |
| 106 | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | НӨАТ, НХАТ-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг хувиар тооцно. | НӨАТ, НХАТ-ын төсвийн татварын орлого нийлбэр дүнгээр 94.4 хувьтай биелүүлсэн | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуульд хамаарах татвар төлөгчийн тоо нэмэгдсэнээр татварын орлого өссөн байна. Төлөвлөгөөг 100 хувь хангаж ажиллана. | 7.0 | Дүүргийн төсөв | ТХ | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдийг төлбөрийн ибаримт олгож хэвшүүлэх, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, дахин давтан зөрчил гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.2, 6.5 дугаар зүйлд заасны дагуу албан татвар суутган төлөгчөөр иргэнийг бүртгэж өөр дүүрэгт бүртгэлтэй 45 иргэний мэдээллийг харьяа татварын албадруу шилжүүлсэн ба бүртгэх ажлыг эрчимжүүлэн масс мессеж хүргүүлэн, судалгааг байцаагч бүрээр хуваарилан утсаар холбогдож ажилласан. Хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар 22-ны өдрийн А/15 тоот тушаалаар 26 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | иргэнийг нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн төрлөөс хассан. 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар дотоодын бараа ажил үйлчилгээнээс суутгасан нэмэгдсэн өртгийн албан татварын төлөвлөгөө өссөн дүнгээр 45,133,365.0 мянган төгрөг, өссөн гүйцэтгэл 47,270,133.0 мянган төгрөг буюу 105 хувийн гүйцэтгэлтэй. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийслэл хотын албан татварын төрлөөр бүртгэлтэй 23 иргэнээс үйл ажиллагаа нь зогссон 2 иргэнийг төрлөөс хасч 12 иргэний тайлангийн тооцоог хийж 69,2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Нийслэл хотын албан татварын өссөн төлөвлөгөө 1,210,139.0 мянган төгрөг, өссөн гүйцэтгэл 1,422,054.0 мянган төгрөг буюу 118 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | |
| 107 | | "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 42 томоохон зах худалдааны төвүүд болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг бүрэн хамруулах, тасралтгүй хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. Татвар төлөгчийг НӨАТУС-д холбосон хувиар тооцно. 2. Холбогдсон татвар төлөгчийг цахим төлбөрийн баримт олголтын хувиар тооцно. | 1. Татвар төлөгчийг НӨАТУС-д 91.0 хувийг холбосон. 2. НӨАТ-ын нэгдсэн системээс төлбөрийн баримт хэвлэж олголт 100 хувь | 1. НӨАТ-ын суутган төлөгчийг НӨАТУС-д 100 хувь холбосон байна. 2. НӨАТУС-д холбогдсон татвар төлөгчийн баримт илгээж буй байдалд хяналт тавьж, баримт илгээхгүй байгаа татвар төлөгчдийг 100 хувь илгээж хэвшүүлсэн байна.. | 15.0 | Дүүргийн төсөв | ТХ | 1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 35 зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг цахим төлбөрийн баримт олгодоггүй бизнес эрхлэгч, лангуу түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд "Татварын ерөнхий хууль" түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, татвар төлөгчдөд зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Хэлтсийн даргын 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн удирдамжийн дагуу 23 татварын улсын байцаагч хяналт тавьж ажилласан. Уг удирдамжит ажлын хүрээнд 5 зах | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | худалдааны төвийг сонгож "Цахимаар үйлчлүүлье" сургалтыг зохион байгуулсан. Гэмтсэн болон шинэ түрээслэгч нарт нийт 115 QR-ийг хэвлэж, наан байршуулсан. Төлбөрийн баримт цөөн тоогоор олгосон 83 иргэнд мэдэгдэл гардуулж 7 татвар төлөгчид зөрчлийн тухай хуулийн дагуу 1,000.3 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. 11-11, 1800-1288 дугаар утас болон ибаримт аплакейшнээр ирүүлсэн гомдлыг бүрэн шийдвэрлэж ажилласан.<br>2. 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн удирдамжийн дагуу хэлтсийн хэмжээнд 48 Татварын улсын байцаагч, хувь хүний татварын тасгийн 10 байцаагчид зах худалдааны төвийг хуваарилан 7 хоног бүр төлбөрийн баримт олголтод хяналт тавин ажилласан. | |
| 108 | | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг төсөвт төвлөрүүлэн ажиллана. | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар тооцно. | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, авто зам ашигласны төлбөр агаарын бохирдлын төлбөрийг төсөвт 72.43 хувьтай биелүүлсэн | 1. АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ-ийн төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байх. 2.Тээврийн хэрэгслүүдийг татварт 100 хувь хамруулсан байна. | 7.5 | Дүүргийн төсөв | ТХ | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/96 тоот захирамж Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/61 тоот тушаал дүүргийн Засаг даргын 2023 оны 03 сарын 06-ны өдрийн А/88 захирамжийг тус тус үндэслэн дүүргийн хэмжээнд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Авто замын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийслэлийн төсөвт автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын төрлөөр 6,865,004.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 6,734,885 мянган төгрөгийг төвлөрүүлж, 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсөвт Агаарын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 150 | НЗДҮАХ-4.3.4, ДЗДҮАХ-4.5.2 | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна | 20 | 20 | | | ЦГ | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаа 8, оюутан цагдаа 36 ажиллуулсан. Олон нийтийн болон оюутан цагдаа нараас тайлант хугацаанд хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 98 удаа 756 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж иргэдэд хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, ухуулга сурталчилгааг давхардсан тоогоор 4500 иргэн, 521 аж ахуй нэгж байгууллагад хийж, 6 нэгдсэн, 16 тусгай арга хэмжээнд оролцсон. Гадаадын иргэд, жуулчдыг халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирхоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Жанжин Сүхбаатарын талбайд 36 чиглэлд 72 "student police"-ын үүрэг гүйцтгэсэн оюутан цагдааг мэргэжлийн удирдлагаар хангаж хамтран ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэнээр хулгайлах гэмт хэрэг 676 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 хувиар буурсан зэрэг үзүүлэлттэй байна. | 100% |
| 151 | НЗДҮАХ-4.3.4.2, ДЗДҮАХ-4.5.3 | Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах "Хүүхэд хамгаалагч" | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 6 | 6 | 5.0 | Дүүргийн төсөв | ЦГ | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/116 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгаалагч" төслийн гэрээг тус дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Сүхбаатар дүүргийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төслийг хэрэгжүүлэх, хүүхдийг гэмт хэрэгт, хохирогч болох эрсдэлийг бууруулах | | | | | | | цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, хүүхэд хамгаалагч ахмад ажилтан нарын дунд дөрвөлсөн гэрээг байгуулан тус дүүргийн 1-20 дугаар хороонд 16 хүүхэд хамгаалагч ахмад ажилтан хичээл эхлэх болон тарах цагуудад хүүхдийг гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэлх замыг бүрэн хяналтад авч, эргүүлийн үүрэг гүйцэтгэн, аюулгүй зорчиход дэмжлэг үзүүлэн ажиллалаа.<br>Хүүхэд хамгаалагч нар нь иргэд, олон нийтээс ирүүлсэн 65 санал хүсэлт, мэдээ мэдээллийг цагдаагийн хэлтэс, Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс болон хамтарсан багт мэдэгдэж, тус хэлтсээс зохион байгуулсан ажил, арга хэмжээнд 15 иргэнийг татан оролцуулж, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй, эрсдэлтэй цаг, эрсдэлтэй орчинд явж байсан 425, замын хөдөлгөөнд оролцоход нь 640 хүүхдэд зөвлөгөө өгч, төөрсөн 35 хүүхдийг эцэг эх асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн. Энэ оны эхний 11 сарын байдлаар насанд хүрээгүй хүнээс үйлдсэн 107 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 нэгжээр буюу 7 хувиар өссөн. Гэмт хэргийн улмаас 169 хүүхэд хохирсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5 нэгжээр буюу 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 152 | ДЗДҮАХ-4.5.4 | Аливаа хүчирхийллийн шинжтэй үйлдлийн эсрэг бүх нийтээр тэмцэх хандлагыг олон нийтэд уриалах "Үрсээ | Зохион байгуулах аяны тоо | 6 | 6 | 5.0 | Дүүргийн төсөв | ЦГ | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан гэр бүлийн тогтвортой харилцааг бэхжүүлэх, хүүхдүүдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, тэдэнд эерэг дурсамж үлдээх зорилгоор дүүргийн оршин суугч хүүхэд багачуудын дунд "Үрсээ хайрлая" өдөрлөгийг 2023 оны | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хайрлая"аян өрнүүлнэ. | | | | | | | 05 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт зохион байгууллаа. Өдөрлөгт алба хаагчдын болон дүүргийн оршин суугч 150 орчим хүүхэд хамрагдсан. Өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд "Пороро ба түүний нөхөд" авьяаслаг багачууд хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлсэн. Мөн гар зургийн уралдаан болон 3 төрлийн хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, нийт хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад амттан, гарын бэлэг гардуулсан. Мөн "Үрсээ хайрлая" сэдэвт 1 төрлийн шторкийг бүтээж, газрын пэйж хуудсанд байршуулан иргэд олон нийтэд түгээж зэргээр нөлөөллийн арга хэмжээ зохион явуулсан. | |
| 153 | | Хүүхдийн эрсэг хүчирхийлэл үйлдэгч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдийн амьдралын хэв маяг, сэтгэл зүйд нөлөөлөх зорилтод арга хэмжээг зохион байгуулна. | Зорилтод арга хэмжээний тоо | 6 | 6 | 5.0 | Дүүргийн төсөв | ЦГ | Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж эерэг хандлагыг бий болгох чиглэлээр "Ажил хийвэл ам тостоно" "Харилцан Хүндэтгэе", "Би гэр бүлдээ хайртай", "Жаргалтай гэр бүл" зэрэг 6 арга хэмжээг, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Улаан загалмайн хороотой хамтарч, хариуцсан нутаг дэвсгэртээ зохион явуулсан. Тус арга хэмжээг зохион байгуулснаар хүчирхийлэл үйлдэж болзошгүй 4500 гаруй иргэнд "Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээлгэх хариуцлага" Гэр бүлийн үнэ цэний талаар сургалт зохион байгуулж, 6 төрлийн зурагт хуудас 2500 ширхгийг хэвлүүлж 4 видео контент бүтээлгэж газар хэлтсийн цахим хуудсанд байршуулж иргэдэд мэдээлэл өгөх зэргээр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | амьдралын хэв маяг, сэтгэлзүйд нөлөөлөх зорилтод арга хэмжээг үе шаттай зохион байгуулсан. | |
| 154 | | Хүүхдэд ээлтэй байх, хүүхдийг аливаа гэмт хэрэг, зөрчил осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулж үр дүнг тооцож ажиллана. | Зохион байгуулах арга хэмжээний тоо хамрагдах иргэдийн тоо | 6 | 6 | 22.5 | Дүүргийн төсөв | ЦГ | Хүүхдийг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хүүхэд хамгаалал-2023" нэгдсэн арга хэмжээг улирал бүр тасралтгүй зохион явуулсан. Арга хэмжээнүүдийн хүрээнд хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, хамгаалан байршуулах, хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нарын хамт 7 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт хараа хяналтгүй хүүхдүүдийг орогнож болзошгүй газрууд болох орц, хонгил 221, гудамж, талбай 54, цахим тоглоомын газар 42, томоохон худалдааны төв 5 зах, олноор төвлөрч, цугладаг 17 автобусны буудал, авто угаалгын газар 23, автомашины засварын газар 21, дулааны худаг 10, фантам, зочид буудал гэх мэт нийт 393 аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийж эцэг эрх, асран хамгаалагчийн хараа хяналт сул, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч болзошгүй 51 хүүхдийг илрүүлж, шаардлагатай холбон зуучлах үйлчилгээг үзүүлж, 49 хүүхдийг Хүүхэд хамгааллын түр хамгаалах байранд хүлээлгэн өгсөн.<br>Эцэг эхчүүдэд хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулах, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх богино хэмжээний 3-н төрлийн видео шторкыг бэлтгэн Цагдаагийн газрын цахим хуудсанд байршуулж иргэдэд түгээсэн. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа хүн, хуулийн этгээдийн бүртгэлд 16 хүнийг бүртгэл хяналтад авсан. | |
| 155 | ДЗДҮАХ-4.5.5 | Хавар намрын хуурайшилтын үед нутаг дэвсгэрийн ногоон бүсэд онцгой байдлын хэлтэс байгаль хамгаалагч нартай хамтарсан эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулна. | 2,3 дугаар улиралд | Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 60 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 70 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулна | 12.5 | Дүүргий н төсөв | ОБХ | 2023 он 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны 11 дүгээр сарын 10-ны Гал түймэр унтраах, аврах 34, 74-р анги, бэлтгэл ээлжийн давхардсан тоогоор 915 алба хаагч 67 удаа, дүүргийн 18, 19, 20 дугаар хорооны нутагт орших Бэлх, Сэлх, Хадат цуурай, Майхан толгой, Баянбулаг, Хандгайт, Яргайтын богино, Янзага зуслан, Шарга морьт, Гоодойн ам зэрэг газруудын амуудаар 11-26 УНҮ, 51-26 УАК улсын дугаартай УАЗ фургон, 54-34 УБУ улсын дугаартай ой хээрийн гал түймэр унтраах зориулалттай 1 тонн усны багтаамжтай Портер маркийн автомашины чанга яригчаар иргэдэд ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэн ажилласан. | 100% |
| 156 | ДЗДҮАХ-4.5.7 | Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах шаардлагатай техник тусгай хэрэгслээр хангана. | Тоног төхөөрөмжийн тоо | Шинээр | 1 ширхэг ус сорох төхөөрөмжний насос, 1 ширхэг хөдөлгөөнт удирдлагын байртай болно. | | Дүүргий н төсөв | ОБХ | Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2023.04.10 ны өдрийн А/111 дүгээр захирамж " Шар өвс-Шатахуунтай адил" аяны хүрээнд "Иж бүрэн зургийн аппарат, Таблет, энгэрийн камер" -ийг нийт төсөв 18,866,200/төгрөг/ төхөөрөмж хэрэгслийг хүлээн авсан. Дүүргийн засаг даргын захирамжаар Дэвшил ХХК, Орон нутгийн үйлдвэрийн газарт 1 ширхэг ус сорох төхөөрөмжний насос худалдан авч өгсөн. Шаардагатай тохиолдолд авч ашиглах зөвшөөрөлтэй. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 157 | ДЗДҮАХ-4.5.9 | Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, хууль сурталчлах сургалт зохион байгуулна. | Сургалт, сурталчилгааны тоо | 2022 онд 50 сууц амчлөгдийн холбоонд сургалт зохион байгуулж, шинээр байгуулагдсан 22 СӨХ-нд холбогдох хууль дүрмийн талаар зөвлөгөө өгсөн. | 2 удаагийн давтамжаар сургалтад 100-гаас доошгүй сууц өмчлөгчдийн холбооны удирдах ажилтанд сургалт зохион байгуулна. | | | ТНААХ | Дүүргийн 11 дүгээр хорооны сууц өмчлөгчдийн холбооны удирдах ажилчидтай 2023 оны 03 дугаар сарын 23-ны хорооны иргэдийн танхимд сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, орчны 50м зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайруулах, сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг суртчилах сургалт зохион байгууллаа.<br>Сургалтанд 45 СӨХ-ны удирдах ажилтан оролцлоо. Үүнд: Тохилог хангай, Хангай хотхон, Шинэ Сити, Баянсоёмбо, Шинэ хангай, Залуус, Ахмадын хотхон, 41а, б , Сэлбэ 86, Эсти апартмент, Тохилог сууц, Эвт хотхон, Аз жаргал, Дархан өргөө, Шинэ иргэн, Ногоон нуурын 52 СӨХ оролцлоо.<br>9 дүгээр хорооны 267 дугаар байрны Гэрэлт титэм СӨХ-ны бүх гишүүдийн хурлыг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, 1 дүгээр хороо 10/3 дугаар байрны Ханбогд СӨХ, 4 дүгээр хороо 22, 24 дүгээр байрны Итгэлцэл сууц өмчлөгдийн холбооны бүх гишүүдийн хурлыг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хорооны ажлын албатай хамтран зохион байгууллаа.<br>2023 оны 07 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд дүүргийн 5 дугаар хорооны 16 СӨХ, 6 дугаар хорооны 18 СӨХ, 8 дугаар хорооны 10 СӨХ, 9 дүгээр хорооны 5 СӨХ , 10 дугаар хорооны 10 СӨХ нийт 59 СӨХ-нд хог хаягдлын тухай хууль, холбогдох журам, стандартын талаарх сургалтыг зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 158 | | Сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна. | Шалгалтад хамрагдсан сууц өмчлөгчдийн холбооны тоо | Дүүргийн нутаг дэвсгэрт 205 СӨХ үйл ажиллагаа явуулж байна. | 205 сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 13.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 230 сууц өмчлөгчдийн холбоонд түвшин тогтоох үзлэг шалгалт хийх хуваарийг хороодоор дамжуулан хүргүүлж 2023 оны 11 дүгээр сарын 22-ноос 30-ны өдрийн хороонд зохион байгуулж ажиллалаа. | 100% |
| 3.6 (4.6) Хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана. | | | | | | | | | | |
| 159 | НЗДҮАХ-3.4.3 НХЖТ-2.3.26 НХЖТ-2.4.17 ДЗДҮАХ-4.6.1 | Аялал жуулчлал, худалдаа, хүнсний болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын соёл, чанарыг сайжруулж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэж, үйлчилгээний байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дэмжиж ажиллана. | Зохион байгуулах арга хэмжээ, ААНБ-ын тоо | 6 удаагийн танхимын сургалтаар 6400 ААНБ, иргэнийг хамруулж, 5 удаагийн нэгдсэн арга хэмжээнд 120 ААНБ-ыг оролцуулж үйлчилгээний салбарын 35 ажиллагсдыг шагнаж урамшуулсан. | Танхимын 4, цахимаар 2, нийт 6 сургалтад 500 ААНБ, иргэнийг хамруулж нэгдсэн арга хэмжээнд хамрагдах ААНБ-ын тоог 30-аар нэмэгдүүлнэ. | | | ХХҮХ | Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад холбогдох хууль тогтоомж, стандартыг сурталчлах зорилгоор нийт 15 удаагийн цахим болон танхимын сургалт, семинар зохион байгууулж, нийт 1400 гаруй ААНБ, иргэдийг хамруулсан. Үүнд:<br>• ХХААХҮЯ, УБЗАА, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоотой хамтран олон улсын аа тухай дэлгүүрийн стандартыг сурталчилж, үндэсний стандарт боловсруулах сургалтад-15;<br>• НЗД-ын Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХСХГ, НАЖГ, Мэргэжлийн Тур операторуудын холбоо, НХХААГ-ын Хяналтын хэлтэстэй хамтран Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага, стандартууд, Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент, ерөнхий шаардлага, хоол үйлдвэрлэлийн газарт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | мөрдөгдөх стандарт шаардлага, Шингэрүүлсэн шатдаг хийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны талаар цогц мэдээлэл өгөх сургалтад-250; • "Хариуцлагатай үйлчилгээг дэмжье" аяны хүрээнд Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудыг танилцуулах 11 удаагийн сургалтад-700 гаруй ААНБ; • УБЗАА, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 251 дүгээр тогтоол, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журмыг танилцуулах "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалт түүний онцлог" сэдэвт сургалтад барьцаалан зээлдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 ААН; • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 159 дүгээр тогтоолоор баталсан Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөр, Өрх бүр үйлдвэрлэгч, Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалтыг дүүргийн ХАБЭА-н салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч 414 ААНБ-ыг хамруулсан. | |
| 160 | НХТЖҮЧ-4.5.2 НЗДҮАХ-3.3.2 НХЖТ- | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг | Вакцинд хамрагдах амьтны тоо, хориглосон бүсээс | ДЗД-ын А/147 дугаар захирамжаар 2985 нохойд вакцинжуулалт, | НМЭГ-аас баталсан тоогоор, хориглосон бүс рүү орж ирсэн малын тоогоор | 7.5 | Дүүргийн төсөв | ХХҮХ | НМЭГ-т 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 2/75 дугаар албан бичгээр Сүхбаатар дүүрэгт мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдах тэжээвэр | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.3.12 НХЖТ-2.3.16 ДЗДҮАХ-4.6.2 | эрчимжүүлэн, зуслангийн бүсүүдэд байнгын хяналт тавьж, мал оруулахгүй байх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | гаргасан малын тоо | туулгалт, халдваргүйтгэлд 8.625 сая төгрөг зарцуулсан. Зөвшөөрөлгүй мал оруулж ирсэн 19 айл өрхийн 733 толгой малыг гаргасан. | | | | | амьтны тоон мэдээллийг /3884 өрхийн 4568 нохой, 45 өрхийн 789 шувуу, 304 тэжээвэр амьтан/ хүргүүлж, ХХААХҮСайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах тухай 01 тоот Албан даалгавар, НОК-ын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай 02 тоот Албан даалгаврыг дүүргийн Мал эмнэлгийн нэгж Овоот гол ХХК-д хүргүүлэн, дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Мал эмнэлгийн үйлчилгээг хэрэгжүүлэх тухай А/203 дугаар захирамжийн дагуу хороодын Ажлын алба, дүүргийн Мал эмнэлгийн нэгж Овоот гол ХХК хамтран 3899 нохойд вакцинжуулалт, туулгалт, орчны ариутгал халдваргүйтгэлийг 9246 м2, үйлчилгээний байгууллагуудын 8086 м2, нийт 17332 м2 талбайд ариутгал хийж, дүүргийн төсвөөс нийт 9,780,000 төгрөг зарцуулсан.<br>Нийслэл, дүүргийн Засаг даргын А/35, А/09, А/19 дүгээр захирамж, УБ хотын ЕМ-ийн баталсан хуваарийн дагуу зуслангийн бүсэд хяналт шалгалтын ажлыг тогтмол явуулж, хориглосон бүсээс 2160 малыг гаргаж, суурин малтай 18 өрхөд Мэдэгдэл, шаардлага хүргүүлж, 9 өрхийн 410 малыг хориглосон бүсээс гаргасан.<br>Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хариулгагүй нэвтэрсэн малыг түр саатуулах, түүнтэй холбогдон гарах зардлыг нөхөн төлүүлэх журмын | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төслийн хэлэлцүүлгийг Цагдаагийн 2 дугаар хэлтэс дээр зохион байгуулж, мал бүхий 10 өрхийг оролцуулж, санал бодлыг сонсож, журамд оруулах саналыг 2023 оны 8/400 дугаар бүхий албан бичгээр УБЗАА-нд хүргүүлсэн. | |
| 161 | | Худалдаа үйлчилгээний газруудад аттестатчиллын шалгалт явуулж, үйлчилгээний газруудын стандартын шаардлагыг хангуулна. | Шалгалтад хамрагдсан ААНБ-ын тоо | 2 удаагийн аттестатчиллаар худалдаа-85, хоол үйлдвэрлэлийн 193, нийт 278 ААН | 2 удаагийн аттестатчиллаар худалдаа-100, хоол үйлдвэрлэлийн 200, нийт 300 ААН | 1.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Холбогдох хууль тогтоомж болон худалдаа, үйлчилгээний стандартын шаардлагыг хангуулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 6 удаагийн хяналт шалгалт явуулж, нийт 883 иргэн, ААНБ-дад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Тухайлбал:<br>• НЗД-ын А/242, ДЗД-ын А/174 дүгээр захирамжийн хүрээнд үйлчилгээний байгууллагуудын гадна орчны стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хоол үйлдвэрлэлийн-40, аялал жуулчлалын-30;<br>• ШӨХТГ-аас ирүүлсэн чиглэл, дүүргийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 100 гаруй худалдааны газруудад бүтээгдэхүүний үнийн мэдээллийг шалгасан;<br>• Дүүргийн Засаг даргын А/465 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн Татварын хэлтэс, Газрын зохион байгуулалтын алба, Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран дүүргийн 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх зах, худалдааны төвүүдэд Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нийт 522 ААН-үүдийг хамруулсан;<br>• НЗД-ын А/1267, А/1292, ДЗД-ын А/505 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 9-12 дугаар хорооны нутаг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ 59, барилгын материалын худалдаа 70, хоёрдогч түүхий эд худалдан авах цэг 5, нийт 104 үйлчилгээний газруудад хяналт шалгалт явуулсан;<br>• НЗД-ын А/1240 дугаар, ДЗД-ын А/480 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 7-17 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 57 нийтийн байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, тайланг нэгтгэн, УБЗАА-д хүргүүлсэн.<br>ХХААХҮСайдын 2023 оны "Хяналтын хуудас батлах тухай" А/540 дугаар тушаал, НЗД-ын 2023 оны А/1116 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 20 ААН-ийн ажлын байранд гүйцэтгэлийн хяналт хийж, тусгай зөвшөөрөл олгох саналыг УБЗАА-д хүргүүлсэн. | |
| 162 | | Түргэн үйлчилгээний цэгт холбогдох журмын хэрэгжилтийг хангуулна. | Нүүлгэсэн ТҮЦ-ийн тоо | 2019 онд-21, 2020 онд-10, 2021 онд-9, 2022-6 ТҮЦ-ийг нүүлгэхэд ДЗД-ийн А/312 дугаар захирамжаар 5.0 сая төгрөг. | ХУЗЗ-ийн хурлаар шийдвэрээр нүүлгэх ТҮЦ-д шаардагдах санхүүжилтээр /40ш/ | 20.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | УБ хотын ЕМ-ээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт байгаа 257 ТҮЦ-үүдийн байршлыг google earth програм дээр байршуулж мэдээллийг хүргүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх тухай А/148 дугаар захирамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан түргэн үйлчилгээний 73 цэгт нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлөх Мэдэгдэл-ийг хүргүүлж, ТҮЦ-үүдийн эзэдтэй холбогдох хууль, дүрэм журмын дагуу дүүргийн ЗДТГ-ын Хууль, | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газартай хамтран сонсох ажиллагаа явуулсан. Иргэдээс ирүүлсэн гомдлуудыг үндэслэн, нийслэл дүүргээс хийгдэж буй тохижилтын ажлуудтай уялдуулан 37 ТҮЦ-ийг нүүлгэн нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн.<br>Дүүргийн 1-10, 11, 12, 14, 16, 20 дугаар хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд зуны түр үйлчилгээ явуулж буй 106 иргэн, ААН-үүдэд 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр үйл ажиллагаагаа зогсоож, нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлөх тухай Мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан. | |
| 163 | | Дүүргийн Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөл болон Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлийг устгах, улсын орлого болгох Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Зөвлөлийн хурлын тоо | ХҮЗЗ-ийн хурал-2 удаа, ЭЗХУОБЗ-ийн хурал 1 удаа | Тухайн цаг үеийн асуудлаар зохион байгуулах хурлын тоогоор | 5.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Дүүргийн Засаг даргын дэргэдэх Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлийг устгах, улсын орлого болгох Зөвлөл нийт 7 удаа хуралдаж, 271ш архи, 351ш пиво, нийт 622 ш согтууруулах ундаа, 9 хайрцаг тамхийг улсын орлого болгох Зөвлөлийн шийдвэрийн дагуу Үнэлгээний комиссоос тогтоосон үнээр гэрээт хүнсний дэлгүүрээр дамжуулан худалдан борлуулж, нийт 1,777,470 төгрөгийг Төрийн сан банкны 100200600910 тоот дансанд төвлөрүүлсэн.<br>Зөрчлийн улмаас хураагдсан 443,130 төгрөгийг дүүргийн Цагдаагийн газраас дүүргийн төсөвт төвлөрүүлж, 8 хайрцаг тамхи, 2 ш хутга, 53ш архи, 654ш пивыг Устгалын комисс холбогдох журмын дагуу устгасан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 164 | НХТЖҮЧ-2.3.7, 4.5.2, НЗДҮАХ-1.1.2, 3.3.1.4, 3.3.3, НХЖТ-2.3.18, НХЖТ-2.3.19, НХЖТ-2.3.22, ДЗДҮАХ-4.6.3 | Хүнсний зохистой хэрэглээ, аюулгүй, баталгаат хүнс сонгох талаар хэрэглэгчийн боловсролыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 3 удаагийн сургалтад 250 ААНБ, иргэн | 4 удаагийн арга хэмжээгээр 300 ААНБ, иргэн | 2.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, соён гэгээрүүлэх, иргэдийн хүнсний боловсролыг сайжруулах зорилтын хүрээнд дүүргийн Тамгын газраас хүнсний бараа бүтээгдэхүүний шошгын мэдээллийг хэрхэн зөв уншиж, хүнсээ зөв сонгох, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар олон нийтэд зориулсан зөвлөмжийн зурагт хуудас, Гранд эвент ХХК-тай хамтран хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа, ногооны ашиг тусын талаарх олон нийтэд зориулсан богино хэмжээний шторкыг СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс пейж хуудас, СБД хоол үйлдвэрлэл, үйлчилгээ фэйсбүүк групп, СБД-Худалдаа, СБД-Зах, худалдааны төвүүд, СБД-үйлдвэрүүд, SBD food чат групп, ХХҮХ-Хороод бүлэг, СБД-ийн 1-10 дугаар хороо, Хойд хороод 11-20 дугаар хороодын мессенжерийн бүлэг чат зэрэг мэдээллийн сүлжээгээр дамжуулан сурталчилж, иргэдийн хүнсний боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 400 гаруй ААН, иргэниг оролцуулж, гарын авлага, материалуудаар ханган ажиллалаа.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/120 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсээс Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтэс, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хоол зүй, | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шим судлалын Монголын нийгэмлэгтэй хамтран хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, хоолны илчлэг шим тэжээллэг чанарыг сайжруулах, хоол үйлдвэрлэлийн бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, хүнсний эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хоол үйлдвэрлэлийн 80 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд сургалт зохион байгуулж, чадавхжууллаа. | |
| 165 | | Хүн амын махны хэрэглээг нэмэгдүүлэх, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн махны жижиглэнгийн болон бөөний өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. | Борлуулалтын цэг болон өргөтгөсөн худалдааны тоо, махны хэмжээ, тн | Жижиглэнгээр-51 дэлгүүр, 9 удаагийн өргөтгөсөн худалдаагаар, нийт 262,3 тн | Дэлгүүрийн тоог 5-аар нэмэгдүүлнэ. Борлуулалтын дүнгээр | 0.5 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан 2023 оны Нийслэлийн хүн амын махны хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний тухай А/12 дугаар тушаалын дагуу дүүргийн хэмжээнд нөөцийн мах худалдах 46 дэлгүүртэй гэрээ байгуулж, махны худалдааг 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, жижиглэнгээр 64,0 тн, 14 удаагийн өргөтгөсөн худалдаагаар нийт 5 байршилд 133,0 тн, нийт дүнгээр 197,0 тн мах худалдаалсан.<br>Нөөцийн махны чанар аюулгүй байдал, хүрэлцээ хангамж, татварын и-баримт олголт, эрүүл ахуй, халдвар хамгаалал зэрэг асуудлаар сургалт, уулзалтуудыг 3 удаа зохион байгуулж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу нөөцийн мах худалдаалж буй 46 дэлгүүрийн үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын орлогчийн баталсан хуваарийн дагуу УБЗАА-ны ХХҮХ, НХХААГ-ын Хяналтын хэлтэс, НМЭГ-ын Хяналтын хэлтэс, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран хяналт тавин ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, дундын зуучлалгүйгээр махыг нийслэл хотын иргэдэд худалдах "Өвлийн идэш" махны өргөтгөсөн худалдааг 2023 оны 11 дүгээр сарын 27-ноос 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд дүүргийн 14 дүгээр хороо, Долоон буудал, Хандгайт 30 дугаар гудамжид ХХААХҮЯ, УБЗАА, НМЭГ, НХХААГ, ХЗДАА-тай хамтран зохион байгуулсан. | |
| 166 | | Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулна. | Борлуулалтын цэгийн тоо, ургацын хэмжээ тн | Өрхийн тариалан эрхлэгчдэд үр авахад дэмжлэг үзүүлж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022.04.25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар 229232 төгрөг зарцуулж, өргөтгөсөн худалдааны 5 байршилд нийт 265.0 тн төмс, хүнсний ногоо борлуулсан. | Өрхийн тариалан эрхлэгч 150 иргэнд ногооны үр худалдан авахад дэмжлэг үзүүлэх, байнгын ногооны борлуулалтын цэгийн засвар үйлчилгээ, Худалдааны цэгийн байршил, борлуулалтын хэмжээгээр | 3.5 | Дүүргийн төсөв | XXYX | Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж, МУ-ын Засгийн газраас Эх орны-Эрүүл хүнс уриан дор зохион байгуулагдаж буй Атрын 4 дүгээр аяны хүрээнд ХХААХҮЯ-аас 80%-ийн хөнгөлөлттэй үнээр олгож буй 13 нэр төрлийн 68 кг хүнсний ногооны үр худалдан авах зардлыг дүүргийн Засаг даргын А/214 дүгээр захирамжаар 888,157 төгрөг шийдвэрлэж, 12-20 дугаар хороодын 184 өрхөд үнэгүй олгож, төмс хүнсний ногоо тариалах QR-ийн хялбаршуулсан зөвлөмж, гарын авлага материалаар хангах ажлыг хороодын Ажлын албадтай хамтран зохион байгуулж, хаврын тариалалтаар нийт 1 ААН, 222 өрхийн тариалан эрхлэгчид 0,29 га-д төмс, 1,11 га-д хүнсний ногоо тариалж, 3,633 төмс, 14,0306 тн хүнсний ногоо, үүнээс (хүлэмжийн 0,4056 га талбайгаас 7,79 тн хүнсний ногоо) хураан авч, хүнсний хангамжаа нэмэгдүүлсэн.<br>Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд "Алтан намар-2023" хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг Хичээнгүй Сайд Б.Цэрэндоржийн гудамжинд 2023 оны 09 дүгээр сарын 04-17- | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ны өдрийн хооронд 14 хоногийн хугацаатай зохион байгуулж, дүүргийн өрхийн тариалан эрхлэгчид болон Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Шаамар, Орхон, Зүүнбүрэн, Мандал, Сант, Сүхбаатар, Баянгол сумдын нийт 20 газар тариалан эрхлэгчдийг дэмжин оролцуулсан. Өргөтгөсөн худалдаа зохион байгуулах зардалд дүүргийн Засаг даргын А/390, А/409 дүгээр 2 удаагийн захирамжаар 17,600,000 төгрөг зарцуулсан. Намрын хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон 6, 7, 12, 14, 16 дугаар хороодод байрлаж байгаа хүнсний ногооны борлуулалтын байнгын цэгүүдээр нийт 23 нэр төрлийн 128,1 тн хүнсний ногоог хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж, 386,0 сая төгрөгийн борлуулалт хийж, ХХААХҮ-ийн Сайдын 2023.08.07-ны өдрийн А/389 дүгээр тушаал, УБ хотын Ерөнхий менежерийн 2023.08.29-ний өдрийн А/211 дүгээр тушаалын хүрээнд "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2023" өргөтгөсөн худалдаанд 15 дугаар хорооны дүүргийн өрхийн тариалан эрхлэгч Х.Лхамсүрэнг дэмжин оролцуулж, 5 төрлийн 6,5 тн хүнсний ногоо худалдаалсан. | |
| 167 | | Хүн амын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоог шинэчилж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн, | Гэрээт газруудын тоо, хүнсний хангамжийн мэдээлэл тоогоор | Дүүргийн жишсэн хүн амын 116572 тоогоор хүнсний тооцоолол хийж, худалдаа-8, хоол үйлдвэрлэл-10, хүнсний үйлдвэр-2, нийт 20 ААНБ-тай гэрээ байгуулсан. | Дүүргийн 2022 оны хүн амын тоонд суурилж, хүнсний хэрэгцээг тооцоолж, гэрээт газруудаас мэдээ авна. | | | ХХҮХ | Дүүргийн 2022 оны хүн амын статистик тоогоор жишсэн хүн ам /115285,3/-ын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоо судалгааг шинэчилж, хүнсний зах, худалдааны төв, дэлгүүрээдээс гол нэрийн барааны нөөцийн мэдээг авч нэгтгэн, Хүнсний хангалтын багийн гамшгийн эрсдлээс | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээ тайланг тогтмол гаргана. | | | | | | | хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, худалдаа 9, хоол 10, үйлдвэр 2, нийт 21 газартай гэрээ байгуулсан.<br>Дүүргийн ЗДТГ-ын байранд 2023.06.07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Стратегийн команд штабын нэгдсэн дадлага сургуулийн танхимын сургалтад оролцсон 90, дадлага сургалтад оролцсон 120 хүний 3 өдрийн хоолны асуудлыг шийдвэрлэсэн.<br>Үргэлжлэн орсон борооны улмаас 2023.07.05-10-ны өдрүүдэд Сэлбэ голын ай сав дагуу дүүргийн 1, 13, 15, 16, 19, 20 дугаар хороодод учирсан гамшиг эрсдэлийг бууруулах, голын далан суваг шуудууг зузаатгах, сэргээн засах, орон сууцны байр хорооллуудын авто зам, байруудын усыг соруулах, лаг шаврыг цэвэрлэх ажилд дайчлагдсан бие бүрэлдэхүүн болон удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан 2371 хүнийг дүүргийн Хүнсээр хангах албатай гэрээ байгуулсан Гамшиг эрсдлийн үед хоол хүнсээр хангах гэрээт хоол үйлдвэрлэлийн 6 газар, худалдааны 1 газраас 34 удаагийн хүргэлтийн үйлчилгээгээр халуун хоол, цай, цэвэр усаар хангаж, дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэл, дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Онцгой нөхцөлд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний хоол, хүнсний зардал гаргах тухай А/317 дугаар захирамж, 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Онцгой нөхцөл байдалд шаардагдах хөрөнгө гаргах | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тухай А/318 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Дүүргийн 16 дугаар хорооны Бэлх, Сэлхийн далангийн шороо цэвэрлэх ажилд 2023.08.08-09-ний өдрүүдэд дайчлагдан ажилласан 150 хүний, 2023.09.04-07-ны өдрүүдэд дүүргийн 1 дүгээр хорооны үерийн далан буулгах, цэвэрлэгээ үйлчилгээний ажилд дайчлагдан ажилласан 95 хүний хоол, хүнсний асуудлыг шийдвэрлэсэн. | |
| 168 | НЗДҮАХ-3.3.3<br>НХЖТ-2.3.22<br>НХЖТ-2.3.23<br>НХЖТ-2.3.25<br>ДЗДҮАХ-4.6.4 | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг сурталчлан таниулна. | Үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийн тоо | Хүнсний үйлдвэрлэл-3, худалдаа-130, хоол үйлдвэрлэл-150 | Хүнсний үйлдвэрлэл-3, худалдаа-150, хоол үйлдвэрлэл-200 | | - | ХХҮХ | Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Монголын ресторан, зоогийн газрын холбоо ТББ-тай хамтран зочлох үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр TECHNOLOGY IN FOOD AND BEVERAGE арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Крокус Эвент холл-д зохион байгуулсан арга хэмжээнд салбарын 40 ААНБ-ыг оролцуулж, аялал жуулчлал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь технологийн оновчтой шийдлүүдийг танилцуулж, олон улсын дэвшилтэт технологиудаас танилцуулсан.<br>Сүхбаатар дүүргийн ХАБЭА-н салбар зөвлөлөөс сургалтын Арш хур ХХК, анхны тусламж, эрүүл мэндийн Төгс төвтэй хамтран дүүргийн 400 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, ажлын байран дээрх осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, хөдөлмөрийн аюулгүй | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байдал, эрүүл ахуйн талаар гарсан хууль эрх зүй, стандартуудыг танилцуулах сургалт зохион байгуулсан.<br>Хүнсний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр улирлын чанартай түр худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд НХХААГ-ын Хяналтын хэлтэс, хороодын Ажлын албатай хамтран хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, Цэрэндоржийн гудамж дахь 24 явуулын хоол үйлдвэрлэлийн болон кофе шоп, зайрмагны худалдаа эрхлэгчидтэй 10 удаагийн уулзалт, хяналт шалгалт зохион байгуулж, үйлчилгээнд тавигдах шаардлага, орчны цэвэрлэгээ үйлчилгээ, хог хаягдлаа хэрхэн хаяж, иргэдэд таатай үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан.<br>Стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн худалдаа, үйлчилгээний байгууллагуудын тоог нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсний дунд худалдааны салбараас 33, аялал жуулчлалын салбараас 4, хоол үйлдвэрлэлийн 2, авто засвар үйлчилгээний 4, нийт 43 ААНБ Стандарт, хэмжил зүйн газраас Тохирлын гэрчилгээ авсан байна. | |
| Дөрөв.Ногоон хөгжлийн бодлого /Амьдрахад таатай сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | |
| 4.1 (5.1) Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг бий болгоно. | | | | | | | | | | |
| 169 | МУХЖТ-5.1.6, НХТЖҮЧ-6.4.1, 6.4.2 НЗДҮАХ-5.1.2 ХАХТ- | Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр | Төсөл арга хэмжээний тоо | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 10, 11, 15 дугаар хорооны нийтийн эзэмшлийн талбайд тохижилтын ажил хийх нийт 689.8 сая | Нийтийн эзэмшлийн талбайд тохижилтын ажил хийх 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 153.4 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 7, 8, 16, 17-р хороодод 4 байршил нийт 1622.98м2 талбайд тохижилт хийх 421.6 сая төгрөгийн төсөвтэй 4 төсөл, арга хэмжээний захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.0.24-ний өдрийн 6/145, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.1.2.1 ДЗДҮАХ-5.1.1 | байгуулах болон шинэчилж, тохижуулна. | | төгрөгийн төсөвтэй 5 төсөл хэрэгжүүлсэн. | | | | | 2023.04.27-ны өдрийн 6/827 дугаартай албан бичгээр тус тус дүүргийн худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн Үүнээс 91.8 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжэг бүрэн хэрэгжүүлсэн. 1 төсөл гэрээ байгуулагдахаар хуулийн хугацаанд хүлээгдэж байна. 1 төсөл тендер зарлагдсан шатанд хэрэгжиж байна. | |
| 170 | ДЗДҮАХ-5.1.2 | Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, тохижилт, цэцэрлэгт хүрээлэн байгуулна. | Төсөл арга хэмжээний тоо | Дүүргийн 1-р хороо, Жамъянгүний гудамжид Өглөөний гудамны тохижилтыг 259.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. | Гэр хороололд тохижилт, ногоон байгууламж, спорт цогцболбор бүхий цэцэрлэгт хүрээлэн барина. | 4,000.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолбор барих 4 тэрбум төгрөгийн зураг төсөл, барилга угсралтын төсөл, арга хэмжээг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.02.15-ны өдрийн 6/278 дугаартай албан бичгээр дүүргийн худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх Билгүүн монгол констракшн ХХК-тай 2023.05.24-ний өдөр гэрээ байгуулан, загвар зураг боловсруулах шатанд хэрэгжиж байна. | 70% |
| 171 | | Сэлбэ голын тохижилтыг сэргээн засварлаж, шинээр тохижуулна. | Ажлын гүйцэтгэл хувиар | Сэлбэ голыг засварлах зураг тeслийг гүйцэтгэж байна. | Дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сэлбэ голын засвар, тохижилт хийж гүйцэтгэсэн байна. | 500.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Сэлбэ, Туул, дунд голын ашиглалт хамгаалалтын ажлыг нийслэлийн төсвөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төсөл, арга хэмжээ цуцлагдсан. | - |
| 4.2 (5.2) Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | |
| 172 | НЗДҮАХ-5.1.1, ДЗДҮАХ-5.2.1 | Камерын арчлалт, хамгаалалтыг сайжруулан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Камерын асалтын хувиар | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийт 284 ширхэг камер ажиллаж байна. | Камерын асалтыг 98 хувиас дээш байлгана. | 250.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орчны хяналтыг сайжруулах зорилгоор ашиглаж байгаа 629 ширхэг хяналтын камерын арчлалт хамгаалалтыг сайжруулж, ашиглагчаар Тэнгэр цэгцрэз ХХК-тай 10 дугаар сарыг дуустал гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллахад камер асалт 98,3% ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 173 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | Гэрэлтүүлгийн асалтын хувиар | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 7450 гэрлийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. | Гэрэлтүүлгийн асалтыг 99.2 хувиас дээш байлгана. | 1,386.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 2023 онд нийт 287 ширхэг гэрэлтүүлгийн шонг тэгшлэх, 606 ширхэг гэрэлтүүлгийн чип, 6415м урт сип кабель, 1845 ширхэг гэрэлтүүлгийн толгой засварласан. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 99,3%-тай байна. | 100% |
| 174 | НЗДҮАХ-6.3.30 ХАХТ-6.3.30.1 ДЗДҮАХ-5.2.1 | Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд гэрэлтүүлэг, камержуулалт хийнэ. | Хөрөнгө оруулалтын дүнгээр | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 6, 8, 9 дүгээр хороодод 175 цэгт камер, 2283м камерын цахилгаан хангамж хийх ажлыг 900.3 сая төгрөгөөр, 19-р хороонд 27 цэгт гэрэлтүүлэг хийх ажлыг 230 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | Шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | 257.8 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 11 дүгээр хороонд хийгдэх 57.8 сая төгрөгийн төсөвтэй гэрэлтүүлгийн ажлын худалдан авалтын захиалгыг боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023.01.24-ны өдрийн 6/145 дугаартай албан бичгээр дүүргийн худалдан авах ажиллагааны албанд бүрэн шилжүүлсэн. Төслийг хүрээнд шинээр 17 ширхэг гэрэлтүүлэг хийж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. | 100% |
| 175 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.2 | Иргэд, аж ахуй нэгж байгууллагатай хамтран ногоон байгууламж нэмэгдүүлнэ. | Тоо хэмжээ, м2 | Сэлбэ голын урсац, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 2022 онд 2200 ширхэг бургас ТББ, иргэдтэй хамтран тарьсан байна. | Ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна. | | | ТНААХ | Хашаандаа сайхан амьдаръя ТББ, Чинаагийн галсан сан ТББ, Танайд мод тарья ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан дүүргийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран сэлбэ голын урсгалыг нэмэгдүүлэх, хамгаалах зорилгоор эрэг дагуу 3860 ширхэг бургас тарьсан байна. | 100% |
| 176 | НЗДҮАХ-5.1.2, ДЗДҮАХ-5.2.3 | Гэр хороололд тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж хайрга, дайрган хучилтыг шинээр хийнэ. | Талбайн хэмжээ, м | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13, 17, 20-р хороонд 4398.4м тоосжилтыг бууруулж, шавар | Дүүргийн 12-16, 18-20 дугаар хороодод 10000м хайрга, дайрган хучилт хийгдэнэ. | 1762.1 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 12, 13, 14, 15, 16, 18, 19, 20 дугаар хороодод 10.8 км талбайд гэр хорооллыг тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж, хайрга дайрган хучилт хийх 1,761.8 сая | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шалбаагийг арилгах дайрган хучилт хийх ажлын 6 төслийг 741.3 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | | | | | төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. | |
| 177 | | Орон сууцны хороолол доторх авто зам, гэр хорооллолын хатуу хучилттай замыг нөхөж иргэдийн эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Талбайн хэмжээ, м2 | 2021 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9822м2 асфальтан замын нөхөөс хийгдсэн байна. | Нийтийн эзэмшлийн авто замын 2000м2 асфальтан зам нөхсөн байна. | 300.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зөв зам ХХК нь орон сууцны хороолол дундах асфалтан замын нөхөөс болох 1389м2, гэр хорооллийн дундах 14,000 м/урт шороон замыг нөхөөс болон тэгшилгээ, хөрс нягтруулалтын ажлыг 2023 оны 5 дугаар сарын 03 -ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 17- ны хооронд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн болно. | 100% |
| 178 | | Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замыг засварлаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Талбайн хэмжээ, м2 | Гэр хорооллын намгархаг, ус тогтдог сул шороон хөрс бүхий иргэд зорчиход хүндрэлтэй байдал үүссэн засварлах шаардлагатай 24728 метр зам байна. | Дүүргийн 11-20 дугаар хороонд 10000 метр замыг засварлана. | 1,000.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/370, А/445 дугаар Захирамжаар гэр хорооллын 9, 11-20 дугаар хорооны борооны усанд эвдэрсэн 257 байршилд 88750м шороон авто замыг 10 машин механизм техник хэрэгсэлээр 15 хүний бүрэлдэхүүнтэгээр сэргээн засварласан. | 100% |
| 179 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1, ДЗДҮАХ-5.2.4 | Нийтийн эзэмшлийн явган замын нөхөн сэргээлтийн ажил, батлагдсан стандартын дагуу болгон өөрчлөн, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. | Талбайн хэмжээ, м2 | Дүүргийн 1-20 дугаар хороонд нийт 125,290.8 м2 талбай явган зам байна. | Дүүргийн 1-20 дугаар хороонд 4875 м2 явган замыг засварлана. | 300.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн 2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 1 байршилд 244м2 талбайд явган хүний замын шинээр хийж гүйцэтгэсэн.<br><br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 байршилд 12,185м2 дугуйн болон явган хүний замыг нийслэлийн Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 180 | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар | Үйл ажилгааны хэрэгжилт, хувиар | Дүүргийн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 12 усан оргилуур байна. | 12 усан оргилуурын засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг хариуцан байнгын ажиллагаатай болгосон байна. | 70.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/177 дугаар Захирамжаар усан оргилуурын засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон. Тус Захирамжийн хүрээнд дүүргийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | | | | | | | Засаг даргын тамгын газрын даргатай байгуулсан ажил гүйцэтгэх 86 дугаар гэрээний дагуу Саут волли ХХК нь 1 дүгээр хороо Хорооны байрны зүүн талд, 2 дугаар хороо 26 байрны урд талд, 4 дүгээр хороо 69 байрны урд талд, 5 дугаар хороо 39-р байрны хойд талд, 6 дугаар хороо 12/2 байрны хажууд, 7 дугаар хороо 4,6 дугаар байрны дунд, 10 дугаар хороо 24 байрны урд талд, 32б байрны хажууд байрлах нийт 8 усан оргилуурын засвар үйлчилгээ, хэвийн ажиллаж байгаа 12 усан оргилуурын ашиглалтын зардлыг СӨХ-д олгосон болно. | |
| 181 | | Хуучирч эвдэрсэн хүүхдийн тоглоом,чийрэгжүүлэлтийн төхөөрөмжийг шинээр сольж хүүхэд тоглох нөхцөлийг бүрдүүлнэ. | Үйл ажилгааны хэрэгжилт, хувиар | Шинээр солих шаардлагатай 10 байршилд хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж байна. | Шинээр солих шаардлагатай 10 байршилд хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж шинэчлэнэ. | 300.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Үүлэн сүндэр ХХК нь 2023-2024 он дамжин хэрэгжихээр 1-13 дугаар хорооны 19 байршилд хүүхдийн тоглоомын талбай шинэчлэхээр ажиллаж байна. | 100% |
| 182 | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | Тоо хэмжээ, м2 | 1-20 дугаар хорооны 186 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. | 1-20 дугаар хорооны 186 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайд засвар, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулна. | 1,300.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 186 байршлын 123254,34м2 талбайн 153 ширхэг сүүдрэвч 4405 м2хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн засвар үйлчилгээг хийлгэхээр 12 бүс болгон аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 7 хоногт 3-4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 183 | ДЗДҮАХ-5.2.5 | Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна. | Модны тоо, зүлэгжүүлсэн талбай хэмжээ, м2 | 2022 онд бүх нийтийн мод тарих өдрөөр дүүргийн хэмжээнд нийт 229 ААНБайгууллагын 2400 иргэн 6885 ширхэг мод, 444 м2 цэцэг, 4971,1 м2 зүлэг ногоон байгууламж шинээр нэмэгдсэн. | Ногоон байгууламжийн тоо 3500- аар нэмэгдсэн байна. | 500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | МУ-ын Ерөнхийлегчийн Мод тарих үндэсний өдөр , Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогчийн 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/06 дугаар албан даалгавараар дүүргийн нутаг дэвсгэрт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор харъяа хэлтэс, албад, иргэн аж ахуй нэгж, байгууллага гаднах орчиндоо мод тарих, өмнөх онуудад тарьсан мод, бутыг арчилж, хамгаалах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, орчны зэрлэг ургамлыг устгах, мод бутны тогоог сэргээж услах зэрэг ажлуудыг хийх талаар үүрэг болгосон.<br>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тус дүүрэг нь дүүргийн Засаг даргын албан даалгавар гарч үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, иргэн аж ахуйн нэгж байгууллага гадна орчиндоо мод бут сөөг тарих, гадна орчны ногоон байгууламжийн цэвэрлэгээ арчлалт хамгаалалт хийх талаар үүрэг өгөгдсөний дагуу 2023 онд нийт 14880 ширхэг мод, бут сөөг тарьж, 91 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн байгаль орчны газрын төрийн санд 1,432,000 төгрөг хандивласан байна.<br>1. Хаврын бүх нийтээр мод тарих арга хэмжээг нийслэлийн хэмжээнд "Ногоон хот-Иргэний оролцоо" уриатайгаар 13 дахь жилдээ зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын албаны хамт олон өнгөрөгч амралтын өдрүүдэд нийтдээ 7620 ш улиас, хайлаас мод тарьж арчлалт | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.<br>2. Намрын улиралд гэр хорооллын айл өрхөөс хүсэлт ирүүлсэн 13-р хорооны 285 айлд 2800 ширхэг жимс жимсгэнийн бут сөөг, олгож арчлалт хамгалаалт, тарих аргачлалыг зааж бүртгэл мэдээллийг авч мэдээллийн сан үүсгэж жил бүр хяналт тавин ажиллах талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан болно.<br>Мөн Хашаандаа сайхан амьдаръя ТББ, Чинаагийн галсан сан ТББ, Танайд мод тарья ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан дүүргийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран сэлбэ голын урсгалыг нэмэгдүүлэх, хамгаалах зорилгоор эрэг дагуу 3860 ширхэг бургас тарьсан байна. | |
| 184 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийж ургалт сайжируулна. | Мод, бутны тоо тоо | Дүүргийн 1-18 дугаар хорооны 160 байршилд 2818 ширхэг мод, бут, сөөг байна. | Дүүргийн 1-18 дугаар хорооны 160 байршилд 2819 ширхэг мод бутыг хэлбэржүүлж, шохойдож шуулт хийсэн байна. | 150.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаан доторх нийт 5547 ш модыг хэлбэржүүлэх ажлыг 8 багц болгон мэргэжлийн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | 100% |
